

БАТЛАВ.

БОАЖЯ-ны ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА _____ (Ц.УРАНЧИМЭГ)

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН.

“ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ийн ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, БАЙГАЛЬ ОРЧИН,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

_____ (ФИЛ АБРАХАМ)



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛДАГ “ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ийн 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР МV-006709/

/АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 2657457/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын ахлах шинжээч _____ /Ц.ЖАРГАЛНЭМЭХ/

Боловсруулсан:

“Оюу толгой” ХХК-ийн ЭМААБОАБ-ын хэлтсийн

Байгаль орчны асуудал хариуцсан менежер

/Т.САМДАНЖИГМЭД/

2024 он

1. ОЮУ ТОЛГОЙ УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
1.1. Ерөнхий танилцуулга	1
1.2. Түүхэн товчоон	2
1.3. Оюу толгой зэс-алтны бүлэг ордуудын геологийн тогтоц.....	2
1.4. Оюу толгойн уурхайн техник эдийн засгийн үндэслэл.....	2
1.5. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3
1.6. Уурхайн үйл ажиллагаа, голлох барилга байгууламжууд	3
1.6.1. Баяжуулах үйлдвэрийн цогцолбор	4
1.6.2. Хаягдлын сан	5
1.6.3. Ил уурхай	7
1.6.4. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт.....	7
1.6.5. Гүний уурхай	7
1.6.6. Тэсрэх бодисын үйлдвэр.....	10
1.6.7. Дулааны төв станц (ДТС)	11
1.6.8. Хаягдлын удирдлагын төв (ХУТ)	11
1.6.9. Ус цэвэршүүлэн савлах үйлдвэр (УЦСҮ)	15
1.6.10. Бетон зуурмагийн үйлдвэр	16
1.6.11. Хүнд машин механизмын засварын цех	16
1.6.12. Бохир ус цэвэрлэх байгууламж (БУЦБ).....	17
1.6.13. Түлшний агуулах ба шатахуун түгээх станц (ШТС)	18
1.6.14. Химийн бодисын агуулах	18
1.7. Оюу толгой ХХК-ийн Байгаль орчны үнэлгээ, холбогдох зөвшөөрлүүд.....	19
1.7.1. Уурхайн зөвшөөрөл	19
1.7.2. Газар ашиглалтын зөвшөөрөл, гэрчилгээ	19
1.7.3. Байгаль орчны үнэлгээ.....	20
1.8. Уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, нийт зардал.....	20
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	22
2.1. Уур амьсгал	22
2.2. Геологийн тогтоц ба геоморфологи	22
2.3. Гадаргын ус	23
2.4. Газрын доорх ус (ГДУ).....	23
2.5. Хөрсөн бүрхэвч	23
2.6. Ургамлын аймаг	23
2.7. Амьтны аймаг	23
2.8. Тусгай хамгаалалттай газар нутаг	24
2.9. Нийгэм, эдийн засаг	25
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	26
3.1. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	26
3.2. Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	26
3.3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	27
3.4. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл	27
3.5. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл.....	27
3.6. Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээний зөвлөмж	28
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	28
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	29
5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	29

5.2. Усны нөөц, чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	34
5.3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	40
5.4. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	42
5.5. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	44
5.6. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ...	46
1. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	49
2. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	51
7.1. Биологийн олон янз байдал талаар баримтлах бодлого	51
7.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	53
3. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	54
Article XII. Хаалтын аудитын зорилго, хамрах хүрээ	54
Article XIII. Амьжиргааг дэмжих хөтөлбөрийн төслийг хэрэгжилтыг үргэлжлүүлэх, Гэрээний хугацаа дууссан төслүүд дээр хаалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх	54
4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	55
5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	57
6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	61
7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	63
12.1. Хөрсний хяналт шинжилгээ	63
12.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ	66
12.3. Усны түвшин, чанарын хяналт шинжилгээ	69
12.4. Ургамлын аймаг, ургамалжилт, нөхөн сэргээлтийн дараах хяналт шинжилгээний хөтөлбөр	74
12.5. Амьтны аймгийн хяналт шинжилгээ	76
8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	79
9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	84

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. “Оюу толгой” ХХК-ийн мэдээлэл.....	1
Хүснэгт 2. “Оюу толгой” ХХК-ийн холбогдох албан тушаалтнуудын мэдээлэл	1
Хүснэгт 3. Оюу толгой уурхайн сүүлийн 3 жилийн үйлдвэрлэлийн мэдээ болон 2024 оны урьдчилсан мэдээлэл.....	3
Хүснэгт 4. Уурхайн талбайд ашиглаж буй бохир ус цэвэрлэх байгууламжууд.....	18
Хүснэгт 5. Газар ашиглалтын зөвшөөрөл, гэрчилгээ.....	19
Хүснэгт 6. “Оюу толгой” ХХК-ийн БОННУ-ний тайлангууд.	20
Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа	20
Хүснэгт 8. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төсвийн задаргаа	21
Хүснэгт 9. Хяналт шинжилгээний үйл ажиллагааны төсвийн задаргаа	21
Хүснэгт 10. Хүн амын тоо (2022 он)	25
Хүснэгт 11. Малын тоо, мян (2022 он)	26
Хүснэгт 12. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	29
Хүснэгт 13. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	34
Хүснэгт 14. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	40
Хүснэгт 15. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	42
Хүснэгт 16. Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	44
Хүснэгт 17. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	46
Хүснэгт 18. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	49
Хүснэгт 19. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	53
Хүснэгт 20. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	54
Хүснэгт 21. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	55
Хүснэгт 22. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	58
Хүснэгт 23. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	61
Хүснэгт 24. Хөрсний хяналт шинжилгээ	63
Хүснэгт 25. Агаарын чанарын хяналт шинжилгээ	66
Хүснэгт 26. Усны түвшний хяналт шинжилгээ.....	69
Хүснэгт 27. Ургамлын аймаг, ургамалжилт, нөхөн сэргээлтийн дараах хяналт шинжилгээний хөтөлбөр	74
Хүснэгт 28. Амьтны аймгийн хяналт шинжилгээний хөтөлбөр.....	76
Хүснэгт . 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгасан ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	81
Хүснэгт . Нэмэлтээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ	82
Хүснэгт . Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	84

Зургийн жагсаалт

Зураг 1. Оюу толгой уурхайн байршил	1
Зураг 2. Оюу толгойн уурхайн ашигт малтмалын нөөцийн схем	2
Зураг 3. Гүний уурхайн хэсэг	4
Зураг 4. Баяжуулах үйлдвэрийн цогцолбор: 1-Хүдрийн агуулах, 2-Хоёрдогч бутлуур, 3-Хүдэр дамжуулагч, 4-Баяжуулах үйлдвэр, 5-Баяжмалын агуулах, 6-Савлах үйлдвэр	4
Зураг 5. Туузан дамжуулагч болон хүдрийн агуулах	5
Зураг 6. Анхдагч бутлуур ба туузан дамжуулагчийн ерөнхий схем	5
Зураг 7. Хаягдлын сангийн ерөнхий төлөвлөлтийн зураг	6
Зураг 8. Босоо ам # 1.	7
Зураг 9. Босоо ам № 2	8
Зураг 10. Гүний уурхайн суултын бүсийг урьдчилсан байдлаар тооцсон зураглал	10
Зураг 11. Тэсрэх бодисын үйлдвэр	11
Зураг 12. Дулааны төв станц	11
Зураг 13. Хог хаягдал булшлах байгууламжийн суурь үеүүд	12
Зураг 14. Хог хаягдал булшлах 3 үүр, аюултай хог хаягдлын ландфилл болон шүүрсэн усыг ууршуулах цөөрөм	13
Зураг 15. Аюултай хаягдлыг хадгалах талбай	13
Зураг 16. Хаягдал дугуй хадгалах талбай	14
Зураг 17. Хаягдал шатаах зуух болон Уураар ариутгах төхөөрөмж	15
Зураг 18. Ус цэвэршүүлэн савлах үйлдвэр	16
Зураг 19. Бетон зуурмагийн үйлдвэр	16
Зураг 20. Хүнд машин механизмын засварын цех	17
Зураг . БУЦБ-1 Оюут ажилчдын суурин	17
Зураг 22. Түлшний агуулах ба шатахуун түгээх станц	18
Зураг . Баяжуулах үйлдвэрийн химийн бодисын агуулах	19
Зураг . Говийн бага дархан цаазат газар (ДЦГ)-ын А, Б хэсэг хүртлэх зай	25
Зураг . Эерэг Нөлөө Ахиу байлгахын тулд хэрэгжүүлэх арга хэмжээний шатлал	51
Зураг . Эрүүл Мэнд, Аюулгүй Ажиллагаа, Байгаль Орчин, Аюулгүй Байдлын хэлтсийн бүтэц, зохион байгуулалт.	79


Хураангуй үгийн жагсаалт

БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОЯБ	Биологийн олон янз байдал
БУЦБ	Бохир ус цэвэрлэх байгууламж
БХХ	Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч
ГДУ	Газрын доорх ус
ГХЗ	Газар хөндөх зөвшөөрөл
ДТС	Дулааны төв станц
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ОТ	Оюу толгой
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
ТЭЗҮ	Техник-эдийн засгийн үндэслэл
УЦСҮ	Ус цэвэршүүлэх ба савлах үйлдвэр
ХӨОГ	Хөрөнгө оруулалтын гэрээ
ХС	Хаягдлын сан
ХУТ	Хаягдлын удирдлагын төв
ХХХ	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч
ШТС	Шатахуун түгээх станц
ЭМААБОАБ	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал

1. ОЮУ ТОЛГОЙ УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Ерөнхий танилцуулга

Уурхайн байршил: Оюу толгой (ОТ) уурхай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутагт харьяалагддаг бөгөөд Улаанбаатар хотоос урагш 640 км, Даланзадгад хотоос зүүн тийш 210 км, Ханбогд сумаас баруун тийш 45 км зайд байрладаг.



Зураг 1. Оюу толгой уурхайн байршил

Ангилал: ОТ уурхай нь Оюу толгой ордоос зэс-алт олборлох, боловсруулах уул уурхайн төсөл бөгөөд 2024 онд Ил уурхай болон далд уурхайгаас хүдэр олборлох үйл ажиллагаа, Гүний уурхайн барилга бүтээн байгуулалт болон бусад шаардлагатай барилга байгууламжийн ажил үргэлжлэн явагдана.

Аж ахуйн нэгжийн мэдээлэл:

Хүснэгт 1. “Оюу толгой” ХХК-ийн мэдээлэл

Аж ахуйн нэгж	Улсын бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг, байршил
“Оюу толгой” ХХК	9019006110	Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах Оюу толгой ордоос зэс-алт олборлох төсөл	Улаанбаатар-14240, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-15, “Моннис цамхаг”

Хүснэгт 2. “Оюу толгой” ХХК-ийн холбогдох албан тушаалтнуудын мэдээлэл

№	Нэр	Албан тушаал
1	Дэйдрэ Лингенфэлдер	Гүйцэтгэх захирал
2	Филип Абрахам	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал (ЭМААБОАБ) хариуцсан Ерөнхий менежер
3	Тулганямын Самданжигмэд	Байгаль орчны асуудал хариуцсан Менежер


1.2. Түүхэн товчоон

Уурхай эхэлсэн огноо: “Оюу толгой” ХХК (хуучнаар Айвенхоу Майнз Монголиа Инк-АММИ) нь Монгол Улсад 1996 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байна. 2009 оны 10 дугаар сард “Айвенхоу Майнз”, “Рио Тинто” компаниуд нь Монгол Улсын Засгийн газартай Хөрөнгө оруулалтын гэрээ (ХӨОГ)-г байгуулсан ба “Оюу толгой” ХХК-ийн нийт хувьцааны 34%-ийг Монгол Улсын төрийн өмчит “Эрдэнэс Оюу Толгой” ХХК, үлдэх 66%-ийг “Рио Тинто” компани эзэмшиж байна.

1.3. Оюу толгой зэс-алтны бүлэг ордуудын геологийн тогтоц

Оюу толгой зэс-алтны орд нь дараах гурван үндсэн хэсгээс бүрддэг. Үүнд: Оюутын бүлэг орд (Өмнөд Оюу, Баруун Өмнөд Оюу, Төв Оюу, холбоос) Хюго Дамметын бүлэг орд (Өмнөд Хюго, Хойд Хюго) болон Херуга орд (Зураг 2).

Оюу толгой зэс-алтны бүлэг ордуудын шинэчлэгдсэн нөөцийг Ашигт малтмалын газрын даргын 2015 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/10 тушаалаар Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгэн авсан.



Зураг 2. Оюу толгойн уурхайн ашигт малтмалын нөөцийн схем

Оюу толгойн бүлэг ордын хайгуулын ажлыг зохих арга аргачлалын дагуу хийж, нөөцийг нь дахин тооцоолсноор 2014 оны байдлаар нийт баттай, бодитой болон боломжтой (А+В+С) зэргийн нөөцийг 6,435,249 мян.тн хүдэрт 0.69%-ийн дундаж агуулгатай зэс (зэсийн дүйцүүлсэн агуулгыг дунджаар 0.88%)-ийг 44,428 мян.тн-оор, 0.30 г/тн - ын дундаж агуулгатай алтыг 1,903 тн-оор, 1.85 г/тн-ын дундаж агуулгатай мөнгийг 11,896 тн-оор, 120 г/тн-ын дундаж агуулгатай молибденыг 205 мян.тн-оор тооцоолж, урьдчилан үнэлсэн баялаг (P1)-аар 309,178 мян.тн хүдэрт 0.45%-ийн дундаж агуулгатай зэс (зэсийн дүйцүүлсэн агуулгыг 0.55%)-ийг 1,399 мян.тн-оор, 0.17 г/тн-ын дундаж агуулгатай алтыг 51 тн-оор, 0.90 г/тн-ын дундаж агуулгатай мөнгийг 277 тн-оор тооцсоныг 2015 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хүлээн авсан ба энэхүү нөөцөд орсон өөрчлөлтийн дагуу техник-эдийн засгийн үндэслэлд нэмэлт тодотгол хийсэн.

1.4. Оюу толгой уурхайн техник эдийн засгийн үндэслэл

Эрдэс баялаг, эрчим хүчний яам Ашигт малтмалын газрын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр 2010 оны 3 дугаар сарын 25-ны өдөр “Оюу толгой” ХХК-ийн боловсруулсан Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Оюу толгой зэс-алтны бүлэг ордыг ашиглах уурхайн, баяжуулах үйлдвэрийн Техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг хэлэлцэж, № 24-01 тоот дүгнэлтийг гаргасан. Энэ дүгнэлтэд үндэслэн Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2010 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 71 тоот тушаалаар Оюу толгойн бүлэг ордыг ашиглах уурхайн, баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г хүлээж авсан.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын орших MV-006709 тоот тусгай зөвшөөрөлд Оюу толгой, MV-015225 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлт Жавхлант, MV-015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлт Шивээ толгой нэртэй Оюу толгойн зэс-алтны бүлэг (Оюут, Хюго Даммет, Херуга) ордуудад 2010-2014 онуудад хийгдсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнд Оюу толгойн бүлэг ордуудын нөөцийг шинэчлэн тогтоосныг Ашигт малтмалын газрын даргын 2015 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/10 тушаалаар улсын нэгдсэн бүртгэлд бүртгэн, уг бүлэг ордыг ашиглах ТЭЗҮ-ийг Ашигт малтмалын газрын даргын 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн т/109 тоот тушаалаар хүлээн авсан.

1.5. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл

2023 оны 3-р улирлын байдлаар Ил уурхайгаас 69,381 мян.тонн уулын цул, үүнээс 39,7 мян.тонн хөрс, 29,681 мян.тонн хүдэр олборлох төлөвлөгөөтэй байна. 2024 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн урьдчилсан төлөвлөлтийг өмнөх онуудтай харьцуулсан байдлаар доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. Сүүлийн 3 жилийн үйлдвэрлэлийн мэдээ болон 2024 оны урьдчилсан мэдээлэл

Үйлдвэрлэлийн мэдээ	2021	2022	2023 он (3-р улирал)	2024*
Нийт олборлосон хүдрийн материал буюу уулын цул /хөрс, хүдэр нийлсэн хэмжээ/ (мян/тонноор)	84,983	76,038	69,381	68,800
Боловсруулсан хүдэр (мян/тонноор)	39,124	39,361.42	29,685	41,738
Үйлдвэрлэсэн зэсийн баяжмал (мян/тонноор)	749.6	615.81	599.67	941.63
Баяжмалын дундаж агуулга (% Зэс)	21.7	21.05	21.25	25.01
Баяжмал дахь металлууд:				
Зэс ('000 тонноор)	163	129.47	127.42	235.54
Алт ('000 унциар)	468	183.79	135.65	240.2
Мөнгө ('000 унциар)	977	871.13	820	1694

Эх сурвалж: www.ot.mn

*-Урьдчилсан байдлаар тооцсон дүн

1.6. Уурхайн үйл ажиллагаа, голлох барилга байгууламжууд

Оюу толгойн орд ашиглалтын цогцолбор төлөвлөгөө, Техник эдийн засгийн төлөвлөгөө болон бусад гол бичиг баримтуудад уурхайн гол барилга байгууламжууд нь MV-006709 лицензийн талбайд байрлаж байхаар тусгасан байдаг. Үүнд:

- Баяжуулах үйлдвэрийн цогцолбор
- Хаягдлын сан
- Ил уурхай
- Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагаа
- Гүний уурхай (Босоо ам-1, 2, 3, 4, 5)
- Налуу ам, туузан дамжуулагч
- Тэсрэх бодисын үйлдвэр
- Төв дулааны станц
- Хаягдлын удирдлагын төв
- Ус цэвэршүүлэх ба савлах үйлдвэр
- Бетон зуурмагийн үйлдвэр
- Хүнд машин механизмын засварын цехийн цогцолбор
- Бохир ус цэвэрлэх байгууламжууд,
- Түлшний агуулах ба Шатахуун түгээх станц зэрэг гол байгууламжууд
- Химийн бодисын агуулахууд



Зураг 3. Гүний уурхайн хэсэг

1.6.1. Баяжуулах үйлдвэрийн цогцолбор

Оюу толгой уурхайн Баяжуулах үйлдвэр нь Оюу толгой зэс-алтны бүлэг ордод байрлах Баруун Өмнөд ордын ил уурхай ба Хойд Хьюго ордын блокчлон олборлох Гүний уурхайгаас жилд 35 сая тонн буюу хоногт 100,000 тонн хүдэр олборлон баяжуулж, зэс-алт агуулах баяжмал үйлдвэрлэнэ. Үйлдвэр нь ойролцоогоор 255 метр урт, 144 метр өргөнтэй талбайг эзлэн баруунаас зүүн чиглэлд сунаж байрлана. Хойд Хьюго ордоос илүү өндөр агуулга бүхий хүдэр олборлохтой холбоотой одоо ашиглагдаж байгаа үндсэн флотаци, баганан флотацийн 2 шугамад тохируулга хийх, баяжмал өтгөрүүлэгч, баяжмал шүүлтүүр, үндсэн флотацийн төгсгөлд хаягдлын камерууд нэмэлтээр суулгах, савлах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил хийгдэхээр төлөвлөгдөж байна.

Цаашид Оюу толгой уурхай далд уурхайг олборлож эхэлсэнтэй холбоотойгоор өндөр агуулгатай хүдрийг боловсруулах шаардлагатай холбоотой баяжуулах үйлдвэрт тоног төхөөрөмжийн өргөтгөл, нэмэлт тоног төхөөрөмж суурилуулах шаардлагатай болсон байна. Зэсийн баяжмалын металл авалтыг 0.43%-тай байсныг 1.51%-тай болгож өсгөх зорилгоор 6 ширхэг баганан хөвүүлэн баяжуулагч, 1 ширхэг өтгөрүүлэгч, 2 ширхэг даралтат фильтр, 2 ширхэг савлах модуль суурилуулахаар төлөвлөсөн байна.



Зураг 4. Баяжуулах үйлдвэрийн цогцолбор: 1-Хүдрийн агуулах, 2-Хоёрдогч бутлуур, 3-Хүдэр дамжуулагч, 4-Баяжуулах үйлдвэр, 5-Баяжмалын агуулах, 6-Савлах үйлдвэр


Хаягдлын сан 2 - ын суурийн ажил болон эхний жилийн далангийн барилгын ажил дэд бүтцийн хамтаар хийгдэж дууссан бөгөөд энэ ажлын хүрээнд Хаягдлын сан 1 дээр ашиглаж байсан эргэлтийн усан сангийн хөвдөг насосыг Хаягдлын сан 2 руу шилжүүлэн байрлуулж угсран ашиглалтанд оруулсан.

Анхдагч бутлуур болон туузан дамжуулагч:



Зураг 5. Туузан дамжуулагч болон хүдрийн агуулах

Үйлдвэрийн ашиглалтын эхний жилүүдэд хүдрийн гол эх үүсвэр нь Баруун Өмнөд ордын ил уурхай байна. Гүний уурхай ашиглагдаж эхэлснээр хүдэр олборлолтын хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ Баруун Өмнөд ордын хүдэр олборлолт аажмаар буурна.



Зураг 6. Анхдагч бутлуур ба туузан дамжуулагчийн ерөнхий схем


1.6.2. Хаягдлын сан

Баяжуулах үйлдвэрийн өтгөрүүлсэн хүдрийн хаягдал хадгалах байгууламж нь баяжуулах үйлдвэрээс зүүн урагш 5.4 км зайд байрладаг. Одоогоор Хаягдлын сан 1-ийг ашиглаж дуусаад түр зогсоосон байгаа бөгөөд Хаягдлын сан 2-ын суурийн бэлтгэл ажил, эхний жилийн далангийн барилгын ажлыг дэд бүтцийн хамтаар хийж ашиглалтанд оруулаад байна. Шинээр ашиглалтанд орсон Хаягдлын сан 2 нь ойроцоогоор 4.8 км² талбайтай, уурхайн лицензийн талбайн хүрээнд бага зэрэг хойш сунган барьсан нь ашиглалтын хугацааг бага зэрэг сунгаж 11.5 жил болгосон. Мөн ингэснээр жилд өгсөх хэмжээг багасгаж, тогтвортой байдлыг сайжруулсан. Эхний жилийн

барилгын ажлын явцад 2 тусгаарлах далангаар гурван дэд сангуудад хуваасан нь хаягдлын налууг зөв гаргаж, тунасан усыг төлөвлөгөөний дагуу цуглуулах зорилготой. Мөн хаягдлын сан 2 дээр далангийн периметрийн дагуу 8-12 гүнтэй шавар түгжээсийг хийж гүйцэтгэсэн нь ирээдүйд гарч болох суурийн нэвчилтийг бууруулах зорилготой юм. Мөн түүнчлэн үүссэн нэвчилтийг цуглуулах системийг далангийн эргэн тойронд урьдчилан бэлдэж өгсөн нь ирээдүйд гарч болзошгүй шүүрэл нэвчилтийн үед хяналтгүй алдагдахаас сэргийлж байгаа юм. Хаягдлын сан 2 нь 427 сая тонн хаягдал агуулах хүчин чадалтай бөгөөд 2034 онд далангийн өндөр эцсийн өндөртөө хүрнэ. Оюу толгой уурхайн Хаягдлын санг ашиглахын зэрэгцээ жил бүр даланг дээш нь өсгөх барилгын ажлыг зэрэг гүйцэтгэдэг онцлогтой.

Хаягдлын сан 2-ын хувьд 2024 онд 2-р өсгөлтийн ажил хийж гүйцэтгэнэ, мөн түүнчлэн зүүн тал руу шүүрэл нэвчилтийн судалгааг үргэлжлүүлэн хийнэ, зүүн талын шүүрэл цуглуулах даланг шинэчилэн засварлаж дахин барьна, мөн хойш нь сунгана, мөн шүүрэл цуглуулах далан дээр байгаа соруулах суурин насосын байрлалыг шилжүүлэн далан дотор оруулах төсөл хэрэгжинэ.

Мөн Хаягдлын сан 1-ээс илүүдэл усыг Хаягдлыг сан 2 луу юүлэх суваг хийж байршуулна. Хаягдлын сан 1-ийн хувьд 2024 онд үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд зөвхөн хаалтын налуулгийн ажлыг урд, баруун, зүүн гэсэн 3 ханан дээр хийж гүйцэтгэнэ. Баруун талд нөхөн сэргээлтийн ургамалжуулалтын туршилтын талбайг бэлтгэхээр төлөвлөж байна.



Зураг 7. Хаягдлын сангийн ерөнхий төлөвлөлтийн зураг

1.6.3. Ил уурхай

Оюу толгой бүлэг ордын Оюутын бүлэг орд (Өмнөд Оюу, Баруун Өмнөд Оюу, Төв Оюу)-ыг ил уурхайн аргаар олборлож байгаа бөгөөд ил уурхайн ашиглалтыг экскаватор-автосамосвалын хослол бүхий технологи хэрэглэн 34 м³ багтаамжтай утгуурт гидравлик экскаватор 2 ширхэг, 56 м³ багтаамжтай утгуурт цахилгаан экскаватор 2 ширхэг, 18 м³ багтаамжтай шанагатай утгуурт ачигч 2 ширхэг болон 290-320 тн даацтай автосамосвал 30 ширхгийг ашиглаж байна.

1.6.4. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт

2024 онд Дугатын дайрганы ордоос 266,490.04 м³ дайрга, Оюут улаан шаврын ордоос 24,000.0 м³ шавар, Оюутолгойн улаан шаврын ордоос 189,260.0 м³ шавар, Халивын элсний ордоос 118,960.0 м³ тус тус олборлохоор төлөвлөөд байна.

Мөн Гүний уурхайн барилга бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай барилгын элсийг орон нутгийн “ИНИА” ХХК-аас 56’814.4 м³ элс, “Говийн сайхан тал” ХХК-аас 57’357.1 м³ элс авч нийлүүлэхээр төлөвлөөд байна.

1.6.5. Гүний уурхай

Босоо ам №1

Босоо ам №1 нь одоогийн байдлаар олборлолтын өмнө шатны гарц, засвар үйлчилгээний босоо амны үүргийг гүйцэтгэж байна. Тус ам нь 7м-ийн голчтой, 1385м гүн хүртэл үргэлжилнэ. Босоо амны цамхаг дээр хоёр хүрд суурилуулагдсан бөгөөд 1 хүрд нь 32 хүний багтаамж бүхий 6 тн даацтай давхар тавцантай клет ажиллуулна. Нөгөө хүрд нь 9.5 тоннын даацтай хүдэр өргөх зориулалттай скиппүүдийг ажиллуулна.



Зураг 8. Босоо ам #1.

Босоо ам №2

Босоо ам №2 бол засвар үйлчилгээ болон үйлдвэрлэлийн зориулалттай ам бөгөөд үндсэн агааржуулалтын агаар орох амнуудын нэгний үүргийг давхар гүйцэтгэж байна. 2018 онд Босоо ам №2-ыг бүрэн малтаж дуусгасан. Тус ам нь 10м диаметртэй, бетон ханан бэхэлгээтэй бөгөөд байнгын ашиглагдах чиглүүлэгч зам төмрийг суулгасан. Босоо амыг 39 тоннын даацтай клетээр тоногдосон бөгөөд уг нэг тавцант клет нь 150 хүний багтаамжтай.



Зураг 9. Босоо ам № 2

Босоо ам № 3

Босоо ам №3 нь Гүний уурхайд цэвэр агаар оруулах 3 дахь буюу хамгийн сүүлд ашиглалтанд орох цэвэр агаарын босоо ам болно. Тус босоо ам нь 10м диаметртай бетонон доторлогоотой өргөх төхөөрөмжөөр тоноглолтгүй гүний уурхайн үндсэн цэвэр агаар оруулах ам болно. Нийт 1148м гүн байгууламж бөгөөд Налуу амны туузан дамжуурга болон Хүдрийн биетийн ойр орчмын нэвтрэлтүүдийг цэвэр агаараар хангах үндсэн үүрэгтэй.

Босоо ам № 4

Босоо ам №4 ашиглалтанд ороход Гүний уурхайн агааржуулалтын дараагийн үе шат эхлэх ба үндсэн эргэлтэнд өөрчлөлт орно. Босоо ам №4 нь бетонон доторлогоотой өргөх төхөөрөмжөөр тоноглолтгүй гүний уурхайн үндсэн бохир агаар гаргах ам бөгөөд 11м диаметртэй, 1171м гүн байгууламж юм. Энэхүү ам нь 4 ширхэг 4140мм диаметртэй MVC150 моделийн Howden маркийн сэнснүүдээр тоноглогдсон ба нийтдээ 2,400м³/сек, 5.7кПа даралттайгаар сорох хүчин чадалтай.

Босоо ам №5

Босоо Ам №5 нь 6.7м диаметртэй бетонон доторлогоотой өргөх төхөөрөмжөөр тоноглолтгүй гүний уурхайн үндсэн бохир агаар гаргах ам болно. Энэ нь хэрэглээн дээр тулгууралсан хувьсах урсгалын горимтой 3 сэнснүүдээр тоноглогдсон ба сэнснүүдийн хувьд 2 дахь үндсэн бохир агаар гаргах Босоо Ам №4 -ийг ашиглалтанд орох хүртэл өндөр ачаалалтайгаар ажиллах төлөвлөгөөтэй байгаа. Хойд Хюго гүний уурхайн үндсэн бохир агаар гаргах байгууламж бөгөөд уурхай ашиглагдах нийт хугацаанд ажиллагаатай байна.

Гадаргууд гаргах конвейрын налуу малталт

Гадаргууд гаргах конвейрын систем нь гадаргууд хүлээн авах конвейерт холбогдож улмаар газар дээгүүрх конвейрт холбогдоно. Гадаргууд гаргах конвейерын систем нь 3 ширхэг 2,200 м урт налуу конвейроос бүтнэ. Энэ материал дамжуулах систем нь хүдрийг дамжуулах байгууламж 5-аас авч гадаргуу руу гаргана. Гадаргуу руу гаргах конвейрын систем нь хүдрийн тээвэрлэлтийн

гол хэрэгсэл болно. Уурхайн эцсийн төлөвлөгөөнд хоёр малталт нь хоёулаа агаар гаргах зам болж ашиглагдана.

Гүний уурхайн 2024 оны нэвтрэлт, ашиглалтын төлөвлөгөө

Гүний уурхайгаас хүдэр олборлох улмаар олборлох үйл ажиллагааг ашиглалтад хүлээн авах улсын комисс Оюу толгой уурхайн талбайд 2022 оны 5 дугаар сарын 24-25 ны өдрүүдэд 16 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж Хойд хюгогийн 1-р давхрын олборлолт, Гүний уурхайн хүдэр ачиж гулсуурын байгууламж, анхдагч бутлуур, босоо ам хүртэл богино туузан дамжуурга, чулуулгийг хөнөгөөр газрын гадаргад гаргах систем, баяжуулах үйлдвэрт хүргэх тээвэрлэлтийн системийн 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 22/24 тоот Уул уурхайн, хүнд үйлдвэрлэлийн яамын улсын комиссын актаар хүлээн авсан.

Гүний уурхай 2023 оны 11 сарын байдлаар нийт 126.9 км-ийн хөндлөн малталт хийсэн бөгөөд 2023 онд нийт 15.1 км хөндлөн болон налуу малталтын ажил, ойролцоогоор 0.95 км босоо амны нэвтрэлтийн ажил хийсэн байна. Налуу амны хувьд туузан дамжуургын барилгын ажил хийгдэж байна.


2024 онд 15.8 км хөндлөн малталт, 0.4 км босоо малталтын ажил хийхээр төлөвлөж байна. Мөн Үндсэн бутлуур 2, хүдэр гулсуурын байгууламжийн ажлууд, хүдэр юүлүүрийн болон бусад хөндлөн бэлтгэл нэвтрэлтүүд, хүдэр юүлүүрийн болон огтолгооны тэсэлгээний ажлууд хийгдэнэ. Харин барилгын ажлын хувьд ган арк суурилуулалтын ажлууд, олборлолтын түвшний бетон замын ажлууд, хүдэр тээвэрлэх системийн 2-р үе шатны дамжуулах станцууд, хүнд даацын тоног төхөөрөмжийн засварын газрын барилгын ажил, босоо ам №3-ын агаар халаагуур, босоо ам №4-ийн сорох сэнсний ажил, үндсэн засварын цехийн барилгын ажлууд тус тус хийгдэнэ.

2024 онд бэлтгэл малталт болон олборлолтын ажлын хүрээнд тодорхой хэмжээний бөхирдол бүхий нийт 7,400.5 мян.тн үйлдвэрлэлийн нөөцийн хүдэр уурхайгаас гаргана. Босоо ам №2-оор 7,141.13 мян.тн үйлдвэрлэлийн нөөцийн хүдэр гаргаж баяжуулах үйлдвэрт тэжээлд өгөх бөгөөд үлдсэн 259.37 мян.тн үйлдвэрлэлийн нөөцийн хүдрийг бага агуулгатай хүдрийн овоолго руу буулгана. Харин Босоо ам №3 болон №4-ийн нэвтрэлтийн үед 112.2 мян.тн хоосон чулуулаг гарах бөгөөд эдгээр хоосон чулуулгийг Босоо ам №3 болон №4-өөр гаргаж Босоо ам №2-ын ард байрлах хаягдлын овоолго руу буулгана.

Гүний уурхайн нөлөөллийн бүс

Оюу толгойн ордын нийт баялгийн 80 гаруй хувь нь буюу хамгийн агуулга сайтай хүдэр нь газрын гүнд орших бөгөөд гүний уурхайг блокчлон олборлох орчин үеийн технологи ашиглан барьж байгуулахаар төлөвлөж байна. Блокчлон олборлох арга нь уулын даралтын хүч буюу газрын татах хүчийг ашиглан гүний уурхайн хүдрийн биетийг доороос нь нурааж олборлох арга юм.

Гүний уурхайн олборлолт тогтвортой түвшинд хүрэх үеэс эхлэн гүний олборлолтын үйл ажиллагааны улмаас үүссэн хоосон орон зай руу газрын чулуулаг нурж, үүний үр дүнд газрын гадарга дээр хагаралт, суулт үүсч эхлэнэ. Олборлолт ахих хэрээр суултын бүс томорч гүнзгийрсээр тогоо хэлбэрийн газрын гадаргын нуралт бүхий хэв шинж бүрэлдэж бий болно. Үүнийг гүний уурхайн үүсмэл тогоо гэж цаашид нэрлэх болно. Хүдрийн биетийн дээрх уулын чулуулгийн геологийн тогтоцоос хамааран тогоо үүсэх үйл явц цаг хугацаа болон орон зайн хувьд харилцан адилгүй байна.



Зураг 10. Гүний уурхайн суултын бүсийг урьдчилсан байдлаар тооцсон зураглал

Газрын гадарга дээр үүсэх үүсмэл тогоо нь тухайн орчны газрын гадаргын болон газрын доорх усны горимд өөрчлөлт, нөлөөлөл үзүүлнэ.

Гүний уурхайн үүсмэл тогооны улмаас үүсэх сөрөг нөлөөллийг зөв оновчтой тодорхойлох, шинжлэх ухааны үндэслэлтэй таамаглах, бууруулах үйл ажиллагааг “Оюу толгой” ХХК, хөндлөнгийн судалгааны байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

1.6.6. Тэсрэх бодисын үйлдвэр

Тэсрэх бодисын үйлдвэр нь химийн бодисын агуулах, үйлдвэрийн барилга, тэсрэх бодисын агуулах зэргээс бүрддэг. Оюу толгой уурхайн гүний болон ил уурхайд ашиглах тэсрэх бодисыг Орика компани ханган нийлүүлдэг. Уурхайн тэсрэх бодисын үйлдвэрийн байгууламжийн онцгой хамгаалалтын зурвас бүхий барилга байгууламжийг 2011 оны 7 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд барьж ашиглалтад оруулсан. Тэсрэх бодисын үйлдвэр нь Оюу толгой уурхайн лицензийн талбай дотор тусдаа 215м x 175м талбайтай хашаан дотор байрладаг. Тэсрэх бодисын үйлдвэрийн барилга нь 35м x 28м хэмжээтэй ба химийн бодис хадгалах 42м x 30м хэмжээтэй 2 байгууламжтай.



Зураг 11. Тэсрэх бодисын үйлдвэр

1.6.7. Дулааны төв станц

Дулааны төв станц (ДТС)-ын барилга байгууламж нь тэнхлэгээрээ 138м х 225м хэмжээтэй болно. Тус дэд станц нь дотроо уурын зуухны байгууламж (хүчин чадал - 2625.3м², өндөр - 33м), галын усны насосны станц (21.3м х 12.7м), трансформатор, машин зогсоол, нүүрсний талбай, хүйтэн индүү, бетон туннел, нүүрс бутлуурын өрөө, нүүрсний конвейр, үлээгүүрийн өрөө, утаа сорох сэнсний өрөө (45м х 6м) зэргээс бүрддэг. Анх 2013 онд 29мВ хүчин чадалтай хоёр зуух, 7мВ хүчин чадалтай хоёр зуух бүхий нийт 72мВ хүчин чадалтай ашиглалтанд орж байсан бол Гүний уурхайн үйл ажиллагаатай холбоотой нэмэлтээр 29мВ хоёр зуухаар 2018 онд өргөтгөл хийснээр нийт 130 мВ хүчин чадалтай болж өргөжсөн.



Зураг 12. Дулааны төв станц

1.6.8. Хаягдлын удирдлагын төв

Олон улсын болон үндэсний стандартын шаардлагад нийцсэн, хог хаягдлыг технологийн дагуу булшлах хэсэг, ууршуулах цөөрөм болон аюултай хог хаягдлыг хадгалах талбай бүхий хаягдлын

удирдлагын төв (ХУТ) уурхайн талбайд ажиллаж байна. ХУТ байгууламж нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

- Хог булшлах байгууламж
- Ууршуулах цөөрөм
- Дахин боловсруулах хаягдал хураах талбай
- Аюултай хаягдлыг хадгалах талбай
- Хаягдал дугуй хадгалах талбай
- Уураар ариутгах төхөөрөмж
- Бордооны талбай

Хог булшлах байгууламж нь нь тус бүрдээ 63,000 м³ багтаамж бүхий 3 хаягдал булшлах үүртэй бөгөөд нийт 21,000м² талбай, 190,000 м³ эзлэхүүнтэй. Хог булшлах байгууламжийн суурь дараах үе давхрагуудаас бүрдэнэ:

1. Нягтаршуулсан шавар – 600 мм
2. 5 мм зузаантай HDPE геомембран
3. Хамгаалагч давхрага – geotextile
4. Ялгарах шингэнийг цуглуулах давхрага
5. Шингэнийг шүүх хайрган давхрага

Хог булшлах үед ялгарах шингэн нь тусгай хоолойгоор ууршуулах санд хураагдана. Ууршуулах сан нь мөн нягтаршуулсан шавар – 600 мм болон 1.5 мм зузаантай HDPE геомембран (үл нэвчүүлэх) давхрагаар тусгаарлагдсан.



Зураг 13. Хог хаягдал булшлах байгууламжийн суурь үеүүд



Зураг 14. Хог хаягдал булшлах 3 үүр, аюултай хог хаягдлын ландфилл болон шүүрсэн усыг ууршуулах цөөрөм

Ууршуулах цөөрөм нь борооны болон хог булшилсан талбайгаас шүүрсэн усыг тогтоон барьж ууршуулах зориулалт бүхий тус бүр нь 3514м² талбайтай 2 ширхэг цөөрөм юм. Уг цөөрөмд борооны ус, бусад байгууламжуудаас ирсэн хаягдал ус болон тосыг нь шүүсэн механик цэвэрлэгээний усыг хийж байна.

Аюултай хаягдлыг хадгалах талбай


Аюултай хаягдлыг устгах, дахин боловсруулах, дахин ашиглах тохиромжтой арга зүй, тодорхой болох хүртэл ХУТ дээрх аюултай хаягдлыг хадгалах талбай дээр аюулгүйгээр хадгалж байна.



Зураг 15. Аюултай хаягдлыг хадгалах талбай

Хаягдал дугуй хадгалах талбай

2017 оны 7 сард дугуй болон резин төрлийн хаягдлуудыг урт болон богино хугацаанд ангилан хадгалах талбайг байгуулсан. Бага оврын дугуй болон зарим нэр төрлийн резин хаягдлыг дахин ашиглалт, дахин боловсруулалтад илгээж байгаа бөгөөд том болон дунд оврын хүнд даацын машин тоног төхөөрөмжийн дугуйг урт хугацаанд аюулгүйгээр хадгалж байна. 2023 оны байдлаар том болон дунд оврын дугуйны нийт хуримтлагдсан хэмжээ 5830.6 тн болсон байна.



Зураг 16. Хаягдал дугуй хадгалах талбай

Уураар ариутгах төхөөрөмж

Уураар ариутгах төхөөрөмж буюу автоклав нь цагт 200кг хог хаягдлыг ариутгах хүчин чадалтай бөгөөд эрүүл мэндийн байгууллагын аюултай, эрсдэлтэй хог хаягдал ариутгах зориулалттай бөгөөд 0.8 м³ эзэлхүүнтэй юм.

Уг төхөөрөмж нь 2 давхаргаас бүтсэн бөгөөд дотор тал нь ган төмрөөр хийгдэж, гадна тал нь Q235-B стандартын ган хавтангаар хийгдсэн. Хяналтын систем PLC болон микро дэлгэцтэй автомат компьютер хяналтын дэлгэцтэйгээр хийгдэж, систем аюулгүй явагдаж байгаа болон тэмдэглэл хийж хэвлэх боломжтой. Уг төхөөрөмж Хятад улсын сүүлийн үеийн GB8599-2008, америк улсын FDA болон EN285, EC/97/23 стандартад тэнцсэн.



Зураг 17. Хаягдал шатаах зуух болон Уураар ариутгах төхөөрөмж

Идэвхгүй хаягдлын талбай

Оюу толгой уурхайн ДТС нь 130 мВт хүчин чадалтай бөгөөд жилд дунджаар 40,000 тн нүүрс ашиглаж 20,000-25,000 м³ үнсний хаягдал үүсдэг. Үнсийг 2023 оны байдлаар идэвхгүй хаягдлын 5-р талбайд хүлээн авч булж устгаж байгаа бөгөөд уг талбай нь Өмнөговь аймгийн засаг даргын 2018 оны 2 сарын 20-ны өдрийн А/139 тоот захирамжаар ашиглах зөвшөөрөл нь баталгаажсан байна. Тус талбай нь ил уурхайн хаягдлын чулуулгийн овоолгыг байгуулах талбайд байрласан бөгөөд энэ нь хаягдлын чулуулгийн овоолго байгуулах талбайн үр ашигтай ашиглалтыг нэмэгдүүлэх зорилготой.

Одоо ашиглаж буй 5-р талбайг 2019 оноос эхлэн ашиглаж байгаа бөгөөд 2022 оны 10 сарын байдлаар талбайн нийт ашиглалт ойролцоогоор 90 гаруй хувьтай байна. Цаашид үнсний хаягдлыг дахин боловсруулах боломжийг үргэлжлүүлэн судлах бөгөөд ил уурхайн хаягдал чулуулгийн овоолго дээр хүчиллэг урсац үүсгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор дахин ашиглахаар төлөвлөж байна.

1.6.9. Ус цэвэршүүлэн савлах үйлдвэр

Ажиллагсдын унд, ахуйн хэрэгцээний усыг хангах зорилгоор ус цэвэршүүлэн савлах үйлдвэр (УЦСҮ)-ийг байгуулагдсан. Үйлдвэрийн барилга нь тэнхлэгээрээ 36м х 40м, өндөр нь 7.25м. Төмөр бетонон суурьтай, сэндвичэн хана бүхий барилга ба цагт 200 баллон ус савлах 400м³ хэмжээтэй 4 ширхэг усан сантай усан насос станц, ус цэвэршүүлэн савлах үйлдвэр гэсэн үндсэн 2 танхимтай. Ус савлах үйлдвэрийг 2011 онд барьж байгуулсан. Гүний хоолойн өндөр эрдэсжилттэй усыг зөөлрүүлэн цэвэршүүлж савладаг.

Энэ үйлдвэрт:

- Гүний хоолойн усыг орчин үеийн урвуу осмосын нано шүүлтүүрээр шүүж;
- Ундны усыг озонор ариутгаж;
- Ахуйн усыг хлоржуулан ариутгаж;
- Зөөлрүүлсэн ундны усыг 18.9 литрийн багтаамжтай баллонд савлан кемпийн дотоод ундны усны хэрэгцээнд ашиглаж байна.



Зураг 18. Ус цэвэршүүлэн савлах үйлдвэр

1.6.10. Бетон зуурмагийн үйлдвэр

Гүний уурхайн барилгын ажилд шаардлагатай бетон зуурмагийг дотооддоо үйлдвэрлэн хангах зорилгоор Бетон зуурмагийн үйлдвэрүүд ажиллуулна. Бетон зуурмагийн үйлдвэр 1-ийн үйл ажиллагаа зогссон. Бетон зуурмагийн үйлдвэр 2-ыг татан буулгаж, Босоо амнуудтай ойрхон илүү өндөр хүчин чадалтай Бетон зуурмагийн үйлдвэр 4-ийг байгуулан ашиглаж байна.



Зураг 19. Бетон зуурмагийн үйлдвэр

1.6.11. Хүнд машин механизмын засварын цех

Говь засварын газар нь 1 ба 2 гэсэн 2 хэсгээс бүрддэг ба хүнд машин механизмын засвар үйлчилгээг хийдэг. Шаланд бетон тэгшилгээ сайтар хийж, машины тос болон бензин, дизель түлшнээс хамгаалсан тусгай зориулалтын бетоны будгаар будаж хамгаалсан. Хаягдал тос, тослох материалыг цуглуулан дахин боловсруулах үйлдвэр лүү явуулах, ачих зориулалтын танк,

төхөөрөмжөөр тоноглогдсон. Ямар нэгэн асгаралт гарсан тохиолдолд хөрсөнд бохирдол үүсгэхгүйгээр цуглуулан хадгалах бетон хашлага, хамгаалалтыг барьж байгуулсан.



Зураг 20. Хүнд машин механизмын засварын цех

1.6.12. Бохир ус цэвэрлэх байгууламж

Оюу толгойн нийт ажилчдын ая тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд уурхайд 2 төрлийн нийт дөрвөн бохир ус цэвэрлэх байгууламж (БУЦБ) үйл ажиллагаа явуулж байна

Уурхайн төв цэвэрлэх байгууламж (БУЦБ-1) нь мембран технологитой ба бохир усанд дараах 4 шатлалтай цэвэрлэгээг хийдэг.

1. Механикийн цэвэрлэгээ механик хог шүүх зориулалттай механик болон автомат сараалж бохир усан дахь хатуу хог хаягдлыг шүүх зориулалттай,
 - Бохир усны элсэн шүүлтүүр,
 - Эргэлдэгч хог шүүгч,
2. Биологийн цэвэрлэгээ
 - Нитратгүйжүүлэх танкнууд болон Биомембран шүүлтүүрүүд
3. Химийн цэвэрлэгээ
 - НАТРИ ГИПОХЛОРИД MBR шүүлтүүрийг цэвэрлэх, угаалт хийх болон ариутгал халдваргүйжүүлэх зориулалтаар хэрэглэнэ
 - ПОЛИАЛЮМИНИЙ ХЛОРИД Бохир усанд бүлэгнүүлэгч зориулалтаар хэрэглэнэ.
4. Шингэн лаг усгүйжүүлэх

Цэвэрлэгдсэн ус өргөх станц болон агаар үлээлгийн станцуудын хэсгүүдтэй бөгөөд тоног төхөөрөмжүүдийг хяналтын өрөөнөөс Скада системээр дамжуулан үйл ажиллагааг бүрэн хянаж ажилладаг болно.



Зураг 21. БУЦБ-1 Оюут ажилчдын суурин

Хүснэгт 4. Уурхайн талбайд ашиглаж буй бохир ус цэвэрлэх байгууламжууд

Бохир ус цэвэрлэх байгууламж	Хүчин чадал
БУЦБ-1 Оюут ажилчдын суурин	2,000 м ³ (8,000 хүн/өдөр)
БУЦБ-2 Манлай ажилчдын суурин	300 м ³ (1,300 хүн/өдөр)
БУЦБ-3 Манлай ажилчдын суурин	300 м ³ (1,300 хүн/өдөр)
БУЦБ-4 Эрчим кемп	240 м ³ (1,000 хүн/өдөр)
Нийт	2,840 м³ (11,600 хүн/өдөр)

1.6.13. Түлшний агуулах ба шатахуун түгээх станц

Уурхайн талбайд дизель түлшний 3 агуулах байдаг ба түгээх эхний байгууламжийг төв Оюут кемпийн өмнө хэсэгт, талбайн баруун хойд буланд байрлуулсан. Хоёр дахь байгууламжийг ил уурхайн хөдлөх тоног төхөөрөмжийг цэнэглэх зориулалтаар ил уурхайн автосамосвалын засварын цехийн өмнөд хэсэгт мөн анхдагч бутлуурын баруун хэсэгт байгуулсан. Гурав дахь түлшний байгууламж нь дизель цахилгаан станцын ойролцоо 220кВ-ын төв дэд станцын өмнөд хэсэгт байрладаг. Ил уурхайн шатахуун түгээх станцад зөвхөн Ил уурхайн том оврын автосамосвалууд шатахуун цэнэглэх зориулалттай ба бусад бага оврын автомашин, хөнгөн тэрэгнүүд бусад шатахуун түгээх байгууламжид шатахуунаа цэнэглэж байхаар аюулгүй ажиллагааны зохицуулалт хийсэн. Ил уурхайн шатахуун түгээх станц (ШТС)-д 400 мянган литрийн багтаамжтай түлшний сав 2 ширхэг, 1 сая литрийн багтаамжтай түлшний сав 2 ширхэг тус тус байдаг. Харин бусад ШТС-нд 50 мянган литрийн багтаамжтай түлшний сав 2 ширхэг, 400 мян литрийн багтаамжтай түлшний сав 2 ширхэг тус тус байдаг.



Зураг 22. Түлшний агуулах ба шатахуун түгээх станц

1.6.14. Химийн бодисын агуулах

Химийн бодисын агуулах нь баяжуулах үйлдвэрийн хажууд МУ-ын холбогдох стандартын дагуу 963.1м² талбайтай ба 33.5м урт, 28.75м өргөн, 8м өндөртэй. Шинэ байгууламж нь утаа мэдрэх, гал унтраах системтэй ба химийн бодис хадгалах өрөөнүүдтэй байна. Агуулахын барилгын ажил нь 2022 онд бүрэн баригдаж дууссан бөгөөд Өмнөговь аймгийн МХГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 16/04/038/137 тоот Улсын байцаагчийн дүгнэлтийг гаргаснаар агуулах нь бүрэн үйл ажиллагаанд ороод байна.



Зураг 23. Баяжуулах үйлдвэрийн химийн бодисын агуулах

Уурхайн бетон зуурмагийн үйлдвэрт шаардлагатай химийн бодисыг хангах зорилгоор Баяжуулах үйлдвэрийн химийн бодисын агуулахыг 2018 онд ашиглалтад оруулсан. Агуулах нь холбогдох стандартын дагуу баригдсан бөгөөд нийт 16,632м³ болон 3,840м³ тус тус багтаамжтай химийн бодисын асгаралтыг цуглуулах, хөрсөнд шингэхээс хамгаалсан бетонон шалтай агуулахууд болно.

1.7. Оюу толгой ХХК-ийн Байгаль орчны үнэлгээ, холбогдох зөвшөөрлүүд

1.7.1. Уурхайн зөвшөөрөл

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV 006709

Хүчинтэй хугацаа: 2010/12/26 – 2033/12/26

1.7.2. Газар ашиглалтын зөвшөөрөл, гэрчилгээ

Газар ашиглалтын зөвшөөрөл болон гэрчилгээг доорхи хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 5. Газар ашиглалтын зөвшөөрөл, гэрчилгээ

№	Газар эзэмших зориулалт	Гэрчилгээний дугаар	Газрын хэмжээ /га/	Хүчинтэй хугацаа
1	Уул уурхайн эдэлбэр газар	000002422	8489.09	2019/12/27-2036/12/27
2	Нисэх буудал	000002413	230.0	2016/04/05-2036/03/28
3	Хаягдлын сан	000002412	64.8	2016/04/05-2036/02/17
4	Баяжуулах үйлдвэрийн Баяжмал ачих талбай	000002411	18.4	2016/04/05-2036/02/17
5	МСҮТ-ийн байр (Ханбогд сум)	0007596	1.0	2013/08/09-2041/08/09
6	Радио холбооны цамхаг	0007600	0.06	2016/09/19-2036/07/20
7	Гүний ус дамжуулах хоолой	000343261	2457.00	2019/12/16-2039/12/16
8	Уулзалтын байр, амралтын газар	000345271	12	2015/09/18-2040/03/17
9	Говийн бүс нутгийн ургамлын тарьц суулгац бэлтгэх үржүүлгийн газар	ХБ сумын 3Д-ын #29 захирамж	5	2011/02/25 хугацаагүй
10	Цахилгаан дамжуулах агаарын шугам	000002414	23,55	2021/03/03-2026/03/03
11	Уурхайн хамгааллын бүс	0000122981	253.2	2022/09/21-2052/09/21

1.7.3. Байгаль орчны үнэлгээ

“Оюу толгой” ХХК нь 2004 оноос хойш нийт 46 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) хийлгэсэн байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа БОННУ-ний тайлангуудыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 6. “Оюу толгой” ХХК-ийн БОННУ-ний тайлангууд.

№	БОННУ тайлангийн нэр	Батлагдсан он
1	Оюу толгойн уурхайн БОННУ-ний нэмэлт, тодотгол	2022
2	Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших MV-0006709 тусгай зөвшөөрөлтэй талбайд “Үүр-2” элсний орд, “Оюу толгой” нэртэй дайрганы үүсмэл ордыг ашиглах төслийн БОННУ	2022
3	Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжүүлэх “Ханбумбат” нисэх онгоцны буудал төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан	2022
4	Оюу толгой – Гашуун сухайт чиглэлийн хатуу хучилттай автозам барих төслийн БОННУ	2021
5	Гүний хоолойн газрын доорх усны нөөцийг Оюу толгой төсөлд ашиглахад БОННУ	2010

1.8. Уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, нийт зардал

Хамрах хүрээ: Оюу толгой уурхайн MV-006709 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдаж байгаа үндсэн олборлолтын үйл ажиллагаанаас гадна уурхайн дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой хэд хэдэн төсөл ашиглалтын талбайн гадна хэрэгжсэн бөгөөд тэдгээрийн БОННУ-г холбогдох хууль, журмын дагуу БОАЖЯ-аар батлуулсан. Уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөн (БОМТ)-д үндсэн олборлох, баяжуулах үйл ажиллагаа болон дараах дэд төслүүдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг нэгтгэсэн болно. Үүнд:

- Уурхайн талбай: Тус компанийн тусгай зөвшөөрөлт талбай (MV-006709)
- Гүний хоолойн ГДУ-ны эх үүсвэрийг ашиглах төсөл,
- Ханбумбат онгоцны буудал,
- Оюу толгой – Гашуун сухайт чиглэлийн хатуу хучилттай автозамын төсөл

2024 оны БОМТ, орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн ажлын зардалд нийт нэг тэрбум есөн зуун тавин таван сая нэг зуун гучин мянган (1,955,130,000.0) төгрөг төсөвлөсөн байна.

Хүснэгт 7. БОМТ-ний зардлын задаргаа

№	Зардлын төрөл			Дүн (төгрөг)
1	Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/			511,660,000
2	Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв			
3	Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	Техникийн	88,600,000	644,110,000
		Биологийн	555,510,000	
4	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв			68,000,000
5	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв			50,000,000
6	Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв			101,000,000
7	Түүх соёлын дурсгалт эд зүйлийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх болон нөхөн олговор олгох арга хэмжээний төсөв			12,000,000
8	Соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төсөв			166,500,000
9	Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв			345,800,000
10	Осол эрсдлийн менежмент			15,785,000
11	Хог хаягдлын менежмент			40,785,000
	НИЙТ ТӨСӨВ			1,955,640,000

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төсвийн задаргаа

№	Үйл ажиллагааны төрөл	Дүн (Төгрөг)
1	Агаар	130,800,000
2	Ус	234,000,000
3	Хөрс	30,660,000
4	Газар	24,000,000
5	Ургамал	41,100,000
6	Амьтан	51,100,000
	Нийт	511,660,000

Хүснэгт 9. Хяналт шинжилгээний үйл ажиллагааны төсвийн задаргаа

№	Үйл ажиллагааны төрөл	Дүн (Төгрөг)
1	Агаар	70,000,000
2	Ус	122,000,000
3	Хөрсөн бүрхэвч	23,100,000
4	Ургамал	59,500,000
5	Амьтан	71,200,000
	Нийт	345,800,000

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Уур амьсгал

Дэлхийн уур амьсгалын ангилалаар Оюу толгой уурхай нь Хуурай, хүйтэн цөл (BWk) бүсэд байрлах¹ бөгөөд хавар, намартаа сэрүүн, зундаа халуун, өвөлдөө хүйтэн, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Энд хавар нь маш хуурай бөгөөд салхи ихтэй. Ханбогд сумын цагуурын харуулын 1976-2019 оны ажиглалтын болон ОТ уурхай дахь цаг уурын автомат станцын 2002-2020 оны мэдээнд хийсэн дүн шинжилгээгээртүс бүс нутгийн жилийн дундаж агаарын температур 7.4°C, хөрсний дундаж температур 9.6°C байна. Агаарын дундаж харьцангуй чийгшил 39.2%, жилд унах нийт хур тунадасны хэмжээ 100.1мм хүрдэг. Хамгийн их хур тунадас буусан жил 2018 бөгөөд тухайн жилийн нийлбэр хур тунадас хэмжээ 216.9мм хүрсэн ба хамгийн бага нь 1982 онд 38.1мм хүрсэн байна. Уурхайн талбай орчмын салхины дундаж хурд 5.4 м/с, их хурд 33.2 м/с (2015.08) хүрч салхилж байжээ. Тус бүс нутагт баруун зүгийн салхи зонхилдог. Салхины чиглэлийн давтамж сар бүрээр хоорондоо харилцан адилгүй байна.

Агаарын сарын үнэмлэхүй их, бага температурын олон жилийн дундаж хэмжээ нь тухайн орон нутаг дахь боломжит хязгаарыг илтгэдэг. Цаг уурын олон жилийн мэдээний цуваагаар үнэмлэхүй хамгийн бага температур нь -31.5°C (2002.12.27), үнэмлэхүй хамгийн их температур нь 42.2°C (2010.07.28) хүрсэн байна. Зуны улиралд хөрсний хамгийн их температур нь 68°C (1984.07.27), өвлийн улиралд -47.0°C (1977.03.19) тус тус ажиглагджээ².

Уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлагаар тус бүс нутагт агаарын температур 0.35°C/10жил эрчимтэйгээр нэмэгдэх, хур тунадас 7.4хувь/10жил эрчмээр өсөх, хуурайшилт буюу гангийн эрчимшил (SPEI) 0.21/10жил нэмэгдэх буюу улам хуурай гандуу болж буй хандлага ажиглагдсан байна³.

2.2. Геологийн тогтоц ба геоморфологи

Оюу толгойн зэс-алтны порфирын ордуудыг агуулсан дүүрэг нь девоноос пермийн үеийн хүчиллэг плутонуудаар зүсэгдсэн, девоны цаг үеийн суурилгаас дундлаг найрлагатай вулканоген, вулканоген хэмхдэслэг, тунамал чулуулаг, атираажилд сул автсан цэрдийн насны тунамал, дөрөвдөгч орчин үеийн сэвсгэр хурдас зэргээс тогтоно. Оюу толгой дүүргийн гадаргууд хагарлууд, атираанууд, сулралын бүсүүд ажиглагддаг. Энэхүү структурууд нь хүдэржсэн биетүүдийн хэлбэр дүрс, анхдагч байрлалыг хянан, хүдэржилтийн шилжилт хөдөлгөөнд нөлөөлсөн байдаг ба хүдэржилтийн дараа үеийн атираажих үйл явцаар улам илүү нийлмэл байдалтай болсон байна.

¹ Peel M., Brain L.F., and Thomas M. 2007. Updated World Map of the Koppen-Geiger Climate Classification. Hydrology and Earth System Sciences. 1633–1644. DOI: 10.5194/hess-11-1633-2007

² Оюу толгой. 2020. Уурхайн талбайн ерөнхий нөхцлүүд. Баримтын дугаар: OT-10-E12-COM-0001-D-Communication

³ Bataa D., Bazartseren B., and Uuganbayar B. 2021. Observed Climate Change at Local Scale – Southeastern Gobi in Mongolia. Монгол орны экосистем ба биологийн төрөл зүйлд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөө, өнөөгийн төлөв байдал эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. Хуудас 9-19.

2.3. Гадаргын ус

Оюу толгой уурхайн талбай нь ус зүйн хувьд дэлхийн ус хагалбарын Төв Азийн гадагш урсацгүй ай савд, Монгол орны Галба-Өөш-Долоодын говийн сав газарт тус тус багтана. Энэ ай сав дахь ихэнх голдрил нь түр зуурын урсацтай бөгөөд жилийн ихэнх хугацаанд хуурай байдаг. Төслийн талбайн баруун хэсэгт Ундай гол хэмээх хуурай сайр байдаг. Энэ гол нь Зайсангийн хэцийн нурууны хажуу бэл, 1461.5 м өндөр уулын өвөр хажуугаас эхэлж Оюу толгой уурхайн тусгай зөвшөөрөл бүхий талбайг хойноос зүүн тийш дайран өнгөрч, урсац нь Галбын говийн хуурай нуурт хүрч сарнидаг. Ундайн сайр Оюу толгой ордын баруун талаар урсан уурхайн эдэлбэр газраас 3 км орчим зайд орших Хүрэн толгойн голд нийлдэг. Зуны эрчимшил ихтэй хур борооны үед уг гол урсацтай болдог.

2.4. Газрын доорх ус

Оюу Толгойн бүлэг ордуудын талбай, тэдгээрийн ойр орчмын гадаргын геологийн 1:10000 машстабтай зураг (А.Финдлай, Д.Гарамжав, К.Пантер, 2001-2003), уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн лицензтэй талбайн өнгөн хөрсний төрлийн зураг (“Оюу Толгой төсөл. Цогцолбор хөгжлийн төлөвлөгөө” тайлан, 2005), АММИ ХХК-ний судлаачид А.Түвдэндорж, С.Санждорж, Г.Өлзийбаяр нарын тодорхойлсон уст үе, алаг цоог усжилттай уст цогцолборыг ялгасан дүн зэргийг харгалзан нийт 12 ус агуулагч үе, ус агуулагч ан цавлаг бүс, үндсэндээ усгүй хурдас, чулуулгийг ялгасан.

2.5. Хөрсөн бүрхэвч

Оюу Толгой уурхайн талбай, түүний дэд бүтцийн зурвасын дагууд говийн бор болон цөлийн цайвар бор хэв шинжийн элцэнцэр, шавранцар механик бүрэлдүүнтэй хөрс зонхилон тохиолдоно. Хөрсний гадарга 70 хүртэлх хувийн чулуун хучаастай, 0-5 см хүртэлх гүнтэй сийрэг, ялтсан бүтэц бүхий өнгөн (Q) бүрхүүлтэй. Ялзмагийн агууламж ядмаг 1 хувь орчим, бүх үе давхаргад карбонат агуулдаг, давсны агууламж 0.1 хувиас ямагт их буюу давсжилт ихтэй, суурьт кальци болон магнийн ионууд давамгайлсан хөрс зонхилон тохиолдоно. Хөрсөн дэх фтор болон хүнцэлийн агууламж MNS 5850:2008 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их хэдий ч хортой болон аюултай агууламжаас бага. Хөрсний эрүүл, бактериологийн хувьд цэвэр, маш бага бохирдолтой буюу эрүүл хөрстэй.

2.6. Ургамлын аймаг

Уурхайн талбайд байх ургамлын аймаг нь Төв Азийн их бүсийн говийн төв бүсийн зүүн өмнөд хэсгийг төлөөлнө. Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн болон Алашаа говийн тойргуудын Галбын говийн дэд мужид хамаарагддаг. Тус муж нь зүүн болон хойд талаараа Монголын чийглэг тал хээр болох Манжуур, баруун болон өмнөд талаараа Алашааны тэгш өндөрлөгийн цөлөрхөг хээрт хамаарагдана. Говийн их бага дархан цаазат газарт ургамлын 410 зүйл бүртгэгджээ (Gunin et al. 1998). 2012 оны судалгаагаар уурхайн талбайд нийт 29 овгийн, 74 төрлийн, 127 зүйлийн ургамлыг тэмдэглэсэн байна. ОТ уурхайн талбайд хийгдсэн судалгааны үр дүнгүүдийг нэгтгэн үзэхэд төслийн талбайд 16 зүйл нэн ховор, 7 зүйл ховор ургамал бүртгэгдсэн байна.


2.7. Амьтны аймаг

Оюу толгой уурхайн талбай, түүний орчимд оршин амьдардаг, нутагладаг, дайран өнгөрдөг хөхтөн амьтад, шувуу, хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлийн бүрдлийн дэлгэрэнгүй жагсаалт, хамгааллын статус, тэдгээрийн амьдрах орчин, тус нутагт тохиолдох магадлал, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр болон төслийн талбай орчим дахь амьтдын хорогдол, шилжилт хөдөлгөөний өнөөгийн түвшнийг төслийн талбай болон түүний орчимд 2003-2010 онуудад мэргэжлийн

байгууллагуудаар гүйцэтгүүлсэн суурь судалгааны ажлын үр дүн, мөн ОТ уурхайн 2011-2022 оны амьтны аймгийн мониторинг судалгааны үр дүнг үндэслэн оруулсан.

Оюу толгой уурхайн үйл ажиллагаа явуулж буй Ханбогд сумын нутаг дэвсгэр нь хөхтөн амьтдын төрөл зүйлээр баялаг бөгөөд улаан дансны ангиллаар бүс нутгийн болон олон улсын хэмжээнд ховор зэрэглэлд орсон тууртан амьтад болох хулан, хар сүүлт зээр, аргаль, янгир тархан байршдаг. Эдгээр төрөл зүйлүүдэд уурхайн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөлөл, тус нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн хэрэгжилт зэргийг хянах үүднээс олон төрлийн төрөл бүрийн судалгаа шинжилгээний ажлуудыг хэрэгжүүлдэг. Тухайлбал, Өмнийн говийн тууртан амьтдын тооллого, Хулан болон Хар сүүлт зээрийн нүүдэл хөдөлгөөний судалгаа, Хулангийн унаганы мэнд үлдэлт, Замын нөлөөлөл гэх мэт судалгаа, хяналт шинжилгээний ажлууд хийгдэж байна.


Хар сүүлт зээрийн судалгааны үр дүнгээс харахад 2021-2022 оны хооронд хүзүүвчтэй 17 зээрээс нийтдээ 142,916 байршлын мэдээлэл ирсэн байна. Эдгээр мэдээлэл дээр боловсруулалт хийж үзэхэд тайлант хугацаанд хүзүүвчтэй зээрүүд багадаа 206 км², ихдээ 13196 км², дунджаар 1887.5 ± 759 км² нутаг дэвсгэрийг хамран хоол тэжээл, ус, улирлаас хамаарсан шилжилт хөдөлгөөнийг хийсэн байна (Зураг 24).



Зураг 24. Хүзүүвчтэй хар сүүлт зээрийн туулсан замнал, дэлгэц нутаг

2.8. Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбайгаас улсын тусгай хамгаалалттай Говийн бага дархан цаазат газар (ДЦГ)-ын А хэсэг 31 км, Б хэсэг 68 км, орон нутгийн тусгай хамгаалалттай Мангасын хүрээ 60 км зайтай оршдог.



Зураг 25. Говийн бага дархан цаазат газар (ДЦГ)-ын А, Б хэсэг хүртлэх зай

2.9. Нийгэм, эдийн засаг

Оюу Толгой уурхайн талбай нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд Улаанбаатар хотоос 550 км зайтай Даланзадгад хотоос 220 км зайтай оршдог. Өмнөговь аймаг нь 2022 оны байдлаар нийт 73,441 хүн бүртгэгдсэнээс Ханбогд суманд 8,469 хүн бүртгэгдсэн байна.

Уурхайн талбайтай хамгийн ойр орших суурин газар нь Ханбогд сумын төв юм. Тус сум нь Монгол улсын өмнөд хилээс 130 км, аймгийн төвөөс 252 км, нийслэл Улаанбаатар хотоос 600 км-т алслагдсан бөгөөд өмнө талаараа БНХАУ-тай, баруун талаараа Баян-Овоо, хойд талаараа Манлай, Цогтцэций сумд, зүүн талаараа Дорноговь аймгийн Хатанбулаг сумтай хил залгана. 1515.1 км² нутаг дэвсгэртэй. Тус суманд зэс, алт, төмрийн орд байхаас гадна дэлхийд ховор армострон болон Монголит гэдэг газрын ховор элементүүд, барилгын материал, палеонтологийн олдвороор элбэг юм. Сумын нутаг дэвсгэрт багтах Гашуун Сухайтын боомт нь ард иргэдэд ойр учраас зах зээл хөгжиж, аж ахуйн амьдралд нь эерэг нөлөө үзүүлж байгаа сумын нэг юм.

Хүснэгт 10. Хүн амын тоо (2022 он)

	Өмнөговь аймаг		Ханбогд сум	
	2021	2022	2021	2022
Хүн амын тоо	72,943	73,441	8,404	8,469
Өрхийн тоо	23,164	23,712	2,116	2,145

Эх сурвалж: www.1212.mn

Өмнөговь аймаг нь 2022 оны байдлаар 2,637,330 тоо толгой мал тоологдсоноос Ханбогд суманд 208,330 мал тоологдсон байна.

Хүснэгт 11. Малын тоо, мян (2022 он)

№		Он	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд
1	Өмнөговь	2021	102.02	31.28	160.58	626.71	1,593.22	2,513.800
		2022	112.45	34.76	164.77	675.72	1649.63	2,637.33
2	Ханбогд	2021	10.39	6.83	32.86	54.24	96.24	200.6
		2022	11.41	8.4	34.42	58.57	95.53	208.33

Эх сурвалж: www.1212.mn

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Оюу Толгой уурхайгаас зэс болон алт олборлох үйл ажиллагааны БОННУ-ээр төслийн гол болон болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

3.1. Агаарын чанарт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

БОННУ болон компанийн дотоод бичиг баримт болох Агаар мандалд ялгарах бохирдлын удирдлагын төлөвлөгөөнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал: хүнд машин механизм, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хүдрийн болон хаягдал чулуулгийн овоолгууд, ил уурхай, тэсэлгээ, дулааны төв станц, түлшний хэрэглээ зэргээс агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй. Эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаанаас жилд ойролцоогоор 1.0-1.2 сая тонн CO₂-е хүлэмжийн хий ялгарснаар агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлэх;
- Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх;
- Уурхайн хаягдлын сангийн далан өндөрлөх, өргөтгөлийн (2-р үүр) барилгын ажлаас тоосжилт үүсэх;
- Баяжуулах үйлдвэрийн анхдагч бутлуур, хүдрийн агуулахаас тоосжилт бий болох;
- Дулааны төв станцын яндангаас агаарт бохирдуулагч хий цацагдаж, агаар орчныг бохирдуулах;
- Хүнд машин механизм засварын газар, машины зогсоол дахь машин, техникууд агаар орчныг бохирдуулж болзошгүй нөлөөлөл;
- Тэсэлгээнээс дуу шуугиан, доргио чичиргээ үүсэх;
- Дулааны төв станцын хэрэгцээнд ашиглах нүүрсний тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх;
- Бүх төрлийн тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх.

3.2. Усны нөөц, чанарт гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

“Оюу толгой” ХХК-ийн усны менежментийн бодлогын хүрээнд уурхайн бүх үйл ажиллагаанд усыг зөв зохистой хэмнэлттэй хэрэглэх, усны хэрэглээг хамгийн бага түвшинд хүргэх, усны дахин ашиглалтыг 80 хувиас дээш байлгах, мөн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутгийн иргэдийн хэрэглээний усны нөөц, чанарыг хэвээр хадгалахыг зорин ажилладаг. БОННУ-ний дагуу усны нөөц, чанарт учирч болзошгүй дараах сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоод байна. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаанд усыг дахин ашиглаагүйгээс усны нөөцөд хохирол учрах
- Усыг хэмнэх, зөв зохистой ашиглах мэдлэг мэдээлэл дутмагаас усны нөөцөд хохирол учрах
- Усны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлээгүйн улмаас усны нөөцөд хохирол учрах
- Газрын доорх ус (ГДУ)-ыг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаар усны нөөцөд хохирол учрах
- Шугам хоолойн гэмтлээс үйлдвэрийн болон ахуйн ус ул хөрсөнд нэвчиж, ГДУ-ны найрлага, шинж чанарт нөлөөлөх
- Хаягдлын сангийн усан толионоос ууршилт бий болж усны алдагдал үүсэх
- Ундай сайрын голдиролд тохируулга хийснээр усны байгалийн горим алдагдах
- БУЦБ-аас бохир ус алдагдаж хөрсний бохирдол үүсэж, ГДУ-ны найрлага, шинж чанарт нөлөөлөх
- Хаягдлийн сангаас шүүрэл үүсэх, далан сэтрэх зэрэг ослоос ус алдагдаж, ул хөрсөөр дамжин ГДУ-ыг бохирдуулж болзошгүй
- Ундны усны чанар алдагдах
- Ус ашиглуулах дүгнэлтэнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглах, бусад зориулалтаар ус ашиглах, бусдад худалдан борлуулж усны нөөцөд хохирол учруулах

3.3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Оюу толгой уурхайн үйл ажиллагаагаар газрын гадаргад овоолго үүсэж гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх, зам, барилга байгууламж баригдаж газрын гадарга эвдэгдэх, ил болон гүний уурхай, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаагаар газрын гадарга, хэвлий ухагдаж хоосон орон зай (ухмал) бий болох, газрын гадаргын суулт үүсэх, тул газрын гадарга, хэвлийн эвдрэлийг аль болох бага хэмжээнд байлгах шаардлагатай. Баяжуулах үйлдвэрийн цогцолбор, Хаягдлын сан, ШТМ-ын агуулах, ШТС, тэсрэх бодисын үйлдвэр, Химийн бодисын агуулах, БУЦБ-аас бохир ус, хортой бодис, ШТМ алдагдсанаар газрын гадарга, хэвлийг бохирдуулах сөрөг нөлөөллүүд үүснэ.

3.4. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагаа, олборлолт, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, барилга байгууламж, автозам байгуулах, ашиглах үед үүсэх дараах сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоод байна. Үүнд:

- Газар ашиглалтын үед хөрсөн бүрхэвч алдагдах
- Хуулсан шимт хөрсийг зүй зохистой хадгалаагаагүйгээс салхинд хийсэн, үржил шим алдагдах.
- Химийн бодис, хаягдлын сангийн шүүрлээр хөрс бохирдох

3.5. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, барилга байгууламж байгуулах, зөвшөөрөлгүй шороон зам ашигласнаас ургамлан нөмрөг, ховор ургамлууд нөлөөлөлд өртөж доройтох, дарагдах, устах эрсдэлүүдийг тооцсон байна.

3.6. Амьтны аймагт нөлөөлөх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээний зөвлөмж

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээгээр Оюу толгой уурхайн үйл ажиллагааны улмаас амьтны аймагт үзүүлж болзошгүй дараах нөлөөллийг тодорхойлж, бууруулах арга хэмжээг төлөвлөсөн. Үүнд:

- Дуу чимээ, гэрлийн нөлөөгөөр амьтад байршиж буй газар нутгаасаа үргэх, дайжсанаар амьдрах орчин шууд бус байдлаар алдагдах
- Амьдрах орчны шууд хомсдол үүсэж хуваагдалд орох
- Амьтад уурхайн тээврийн хэрэгсэлд дайруулах, хууль бус ан агнуурт өртөх, шувууд цахилгаанд цохиулах, цахилгааны утас мөргөх зэргээс шууд үхэл хорогдол үүсэх
- Зам болон дэд бүтцийн байгууламжийн улмаас хэсэгчлэн хуваагдсан экосистемээс үүссэн биологийн төрөл зүйлүүд хуримтлагдах нөлөөлөлд өртөх
- Баяжуулах үйлдвэрээс ХС руу нийлүүлж буй хаягдал усны гадаргуу дээр шувууд бууж, хордож болзошгүй
- Аюултай хог хаягдлын ландфилл руу амьтад / элдэв идэшт шувуу гэх мэт/ идэш тэжээл хайж ирж болзошгүй

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго, зорилт: Оюу толгойн уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2022 онд “Грийн трендс” ХХК-ийн боловсруулсан “Оюу толгойн ордоос зэс, алт олборлох, боловсруулах төслийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол тайлан”-гаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Хамрах хүрээ: Оюу толгойн уурхайн MV-006709 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдаж байгаа үндсэн олборлолтын үйл ажиллагаанаас гадна уурхайн дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой хэд хэдэн төсөл ашиглалтын талбайн гадна хэрэгжсэн бөгөөд тэдгээрийн БОННУ-г холбогдох хууль, журмын дагуу БОАЖЯ-аар батлуулсан. Уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндсэн олборлох, баяжуулах үйл ажиллагаа болон дараах дэд төслүүдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг нэгтгэсэн болно. Үүнд:

- Уурхайн талбай: Тус компанийн тусгай зөвшөөрөлт талбай (MV-006709)
- Гүний хоолойн ГДУ-ны эх үүсвэрийг ашиглах төсөл,
- Ханбумбат нисэх буудал,
- Оюу толгойгоос Гашуун Сухайтын чиглэлийн хатуу хучилттай автозам барилгын төсөл.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлээ болон компанийн дотоод бичиг баримт болох Агаар мандалд ялгарах бохирдлын удирдлагын төлөвлөгөөнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал: хүнд машин механизм, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хүдрийн болон хаягдал чулуулгын овоолгууд, ил уурхай, тэсэлгээ, дулааны төв станц, түлшний хэрэглээ зэргээс агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй. Эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах 16 арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 12. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаар мандалд хүлэмжийн хий ялгарах	Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр - хүлэмжийн хийг ялгаруулж буй эх үүсвэрүүдийн мэдээллийг бүртгэх, тооцоолох	Оюу толгойн уурхайн талбайд	Нэгж тайлан	500,000	12	6,000,000	Сард нэг удаа	MNS ISO 14064.1.2015 Хүлэмжийн хий - Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж;
2	Агаар мандалд хүлэмжийн хий ялгарах	Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр - Эрчим хүчийг хэмнэж үр ашигтай зарцуулах	Оюу толгойн уурхайн талбайд	тонн CO2-е	10,000,000	Тодорхойлох боломжгүй	10,000,000	Жилийн турш	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УИХ-ын тогтоол 2011.01.06)
3	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх (дулааны улиралд усалгааг тогтмол хийх)	Оюу толгойн уурхайн талбайн дотоод зам, нисэх буудал хүртэлх зам зэрэг шаардлагатай бүх зам	Нэгж усалгаа	20,000	Тодорхойлох боломжгүй	7,300,000	Жилийн турш	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
									Техникийн ерөнхий шаардлага" MNS 5885:2008 "Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага" MNS ISO 4227:2002 "Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө" MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"
4	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа тогтсон хуваарийн дагуу хийх	Ил уурхай, Хаягдлын сан болон түүний орчимд ашиглагдаж буй замууд, дэд бүтцийн дагуух замууд	Км Мото/ цаг	1,200,000	12	14,400,000	Жилийн турш (Хуваарийн дагуу)	
5	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. Тээврийн хэрэгслүүдэд байрлуулсан GPS-ийн мэдээнд хяналт тавих (шаардлагатай бол хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээ байрлуулах)	Уурхайн талбайн дотоод болон талбайн гадна ашиглагдаж буй замууд	Тодорхойлох боломжгүй	6,000,000	Тодорхойлох боломжгүй	6,000,000	Жилийн турш	
6	Уурхайн ажиллагааны идэвхитэй бүсэд тоосжилт үүсэх	Олборлолт, тээвэрлэлт, барилгын үйл ажиллагаа явуулж буй талбайнуудад усалгаа хийх	Ил уурхай, хаягдлын сан 1, 2	Нэгж усалгаа	20,000	Тодорхойлох боломжгүй	7,300,000	Жилийн турш	"Агаарын тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага"

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
7	Баяжуулах үйлдвэрийн анхдагч бутлуур, хүдрийн агуулахаас тоосжилт бий болох	Баяжуулах үйлдвэрийн анхдагч бутлуур, хүдрийн агуулахаас тоосжилт бий болохоос сэргийлж тоос дарагч бодисыг ашиглах	Анхдагч бутлуур хүдрийн агуулах	тн	200,000	Тодорхой лох боломжгүй	12,000,000	Жилийн турш	Монгол Улсын Агаарын тухай хууль; MNS4585:2016 Агаарын чанарын стандарт-Техникийн ерөнхий шаардлага
8	Дулааны төв станцын яндангаас агаарт бохирдуулагч хий цацагдаж, агаар орчныг бохирдуулах	Дулааны төв станцын технологид тохирсон нүүрс хэрэглэх	Дулааны төв станц	тн	5,000,000	Тодорхой лох боломжгүй	5,000,000	Жилийн турш	Монгол Улсын Агаарын тухай хууль; MNS6298:2001, MNS6342:2012, MNS6342:2012, MNS5457:2005, MNS5919:2008
9	Дулааны төв станцын яндангаас агаарт бохирдуулагч хий цацагдаж, агаар орчныг бохирдуулах	Дулааны төв станцад засвар үйлчилгээг тухай бүр хийх, бохирдуулагчийн ялгарлыг шүүж, стандарт хэмжээнд барих шүүлтүүр ашиглах	Дулааны төв станц (ДТС-н 6 зуухны шүүлтүүрүүдийг 2022, 2023 онд сольсон тул 2024 онд зөвхөн засвар үйлчилгээний ажил хийгдэнэ)	Нэгж шүүлтүүр	10,000,000	Хуваарийн дагуу	10,000,000	Жилийн турш (төлөвлөгөөний дагуу болон шаардлагатай тохиолдолд)	Монгол Улсын Агаарын тухай хууль; MNS6298:2001, MNS6342:2012, MNS6342:2012, MNS5457:2005, MNS5919:2008
10	Дулааны төв станцын яндангаас агаарт бохирдуулагч хий цацагдаж, агаар орчныг бохирдуулах	Утаанд агуулагдах хүхрийн давхар ислийг бууруулах зорилгоор шохойн чулуу ашиглах	Дулааны төв станц	тн	5,000,000	Тодорхой лох боломжгүй	5,000,000	Жилийн турш	Монгол Улсын Агаарын тухай хууль; MNS6298:2001, MNS6342:2012, MNS6342:2012, MNS5457:2005, MNS5919:2008
11	Хүнд машин механизм засварын газар, машины зогсоол дахь машин,	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм ас ялгарах хорт утааг стандартын	Уурхай, дэд бүтцийн шугамын дагууд ашиглагдаж байгаа	Засвар үйлчилгээ	5,000,000	Хуваарийн дагуу	5,000,000	Жилийн турш	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль;

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	техникүүд агаар орчныг бохирдуулж болзошгүй нөлөөлөл	түвшинд байлгах - Уурхайн үйл ажиллагаа болон барилгын ажилд ашиглаж байгаа бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	нийт тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм;						MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"
12	Нүүрс тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх	Дулааны цахилгаан станцад нийлүүлэх нүүрс тээвэрлэгч тээврийн машиныг бүтээлгэтэй байлгах, хяналт тавих	Нүүрс тээвэрлэлтийн зам дагуу	Тээвэрлэлтийн тоо	5,000,000	Тодорхой лох боломжгүй	5,000,000	Жилийн турш	"Агаарын тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага"
13	Бохир цэвэршүүлэх байгууламж, хог хаягдал боловсруулах төв	Ахуйн бохир болон хоолны үлдэгдлийг зориулалтын битүү машинаар тээвэрлэх	Уурхайн талбайд тээвэрлэлт хийх үед	Тээвэрлэлтийн тоо	5,000,000	Тодорхой лох боломжгүй	5,000,000	Жилийн турш	"Агаарын тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага"
14	Тэсэлгээнээс дуу шуугиан, доргио чичиргээ үүсэх	Тэсэлгээний үйл ажиллагааг явуулахдаа агаарын доргилт чичиргээний талаарх үндэсний болон олон улсын стандартын дагуу гүйцэтгэх	Ил уурхай болон уурхайн ажилчдын суурин	Тэсэлгээн ний тоо	10,000	120 (Жилд хийгддэг тэсэлгээний тоо, олон жилийн дунджаар)	12,000,000	Жилийн турш	Монгол улсын хууль "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай"

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
15	Уурхайн үйл ажиллагааны тээвэрлэлтээс үүссэн тоосжилт, агаарын бохирдол үүсэх	Оюу толгой уурхайгаас Таван толгойн нүүрсний зам хуртэлх сайжруулсан шороон замд тоосжилтыг бууруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ	Оюу толгой уурхайгаас Таван толгойн нүүрсний зам хуртэлх сайжруулсан шороон зам	Тоос дарах бодисын хэмжээ, тн	200,000	60	12,000,000	Жилийн турш	"Агаарын тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага"
16	Кэмп, оффисууд дахь агааржуулалт, хөргөлтийн системийн үйл ажиллагаанаас дуу шуугиан үүсэх	Агааржуулалт, хөргөлтийн системийн засвар үйлчилгээг тухай бүр хийх	Уурхайн талбай	Засвар, үйлчилгээний тоо	8,800,000	Тодорхой лох боломжгүй	8,800,000	Жилийн турш	"Агаарын тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага"
	Нийт						130,800,000		

5.2. Усны нөөц, чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Оюу толгой” ХХК-ийн усны менежментийн бодлогын хүрээнд уурхайн бүх үйл ажиллагаанд усыг зөв зохистой хэмнэлттэй хэрэглэх, усны хэрэглээг хамгийн бага түвшинд хүргэх, усны дахин ашиглалтыг 80 хувиас дээш байлгах, мөн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутгийн иргэдийн хэрэглээний усны нөөц, чанарыг хэвээр хадгалахыг зорин ажилладаг. Уурхай зүгээс усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах зорилгын хүрээнд дараах 14 арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.

Хүснэгт 13. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн үйл ажиллагаанд усыг дахин ашиглаагүйгээс усны нөөцөд хохирол учрах	Уурхайн нийт усны дахин ашиглалтын хэмжээг босго түвшин (80%) - ээс дээш байлгах	Ил Уурхай, Баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн хэлтэс болон Гэрээт компаниуд	Дахин ашигласан усны хэмжээ (%)	2,000,000	12	24,000,000	Сард нэг удаа	“Усны тухай” хууль, “Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө”, дотоод журам
2	Усыг хэмнэх, зөв зохистой ашиглах мэдлэг мэдээлэл дутмагаас усны нөөцөд хохирол учрах	Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	Үндсэн болон гэрээт компанийн ажилчид, зочид	Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо	2,000,000	Шинэ ажилчид, зочид	2,000,000	Шинээр ажилд орж буй бүх ажилчид, зочид сургалтанд хамрагддаг.	Компанийн дотоод журам
3	Усны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлээгүйн улмаас усны нөөцөд хохирол учрах	Усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	Ил Уурхай, Баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн хэлтэс болон Гэрээт компаниуд	Усны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2,000,000	12	24,000,000	Жилийн турш	“Усны тухай” хууль, Ус бохирдуулсны төлбөрийн журам. Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм. Байгаль орчны

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
									болон Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан тушаал 167/335/A171
4	Усны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлээгүйн улмаас усны нөөцөд хохирол учрах	Баяжуулах үйлдвэрт 1 тонн хүдэр боловсруулахад ашиглаж байгаа усны хэмжээг (547 л/т хүдэр) хэтрүүлэхгүй байх	Оюу толгой уурхай, Баяжуулах үйлдвэр	Сар бүрийн ус ашиглалтын мэдээ	2,000,000	12	24,000,000	Сард 1 удаа	Компанийн дотоод журам, усны менежментийн төлөвлөгөө
5	Усны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлээгүйн улмаас усны нөөцөд хохирол учрах	Гүний хоолойн ГДУ-ны ордын ашиглалтын 28 худгийн ундаргыг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтгүүлэн ашиглахгүй байх	Гүний хоолойн ашиглалтын 28 худаг	Сар бүрийн ус ашиглалтын мэдээ	2,000,000	12	24,000,000	Сард 1 удаа	Компанийн дотоод журам, усны менежментийн төлөвлөгөө
6	ГДУ-ыг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаар усны нөөцөд хохирол учрах	Гүний хоолойн ГДУ-ны ордын ашиглалтыг батлагдсан нөөцийн (918 л/с) хэмжээнээс хэтрүүлэхгүй байх	Гүний хоолойн ашиглалтын 28 худаг	Сар бүрийн ус ашиглалтын мэдээ	2,000,000	12	24,000,000	Сард 1 удаа	Компанийн дотоод журам, усны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
7	Шугам хоолойн гэмтлээс үйлдвэрийн болон ахуйн ус ул хөрсөнд нэвчиж, ГДУ-ны найрлага, шинж чанарт нөлөөлөх	Үйлдвэрийн болон ахуйн ус дамжуулах шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтад тогтмол хяналт тавьж, гэмтсэн тохиолдолд засах	Оюу толгойн уурхай	Хяналт шалгалт болон засвар үйлчилгээ хийсэн тухай мэдээлэл	15,000,000	Тодорхойл ох боломжгүй	15,000,000	Жилийн турш	MNS0900:2018. Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ”- MNS4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар, хаягдал ус. Ерөнхий шаардлага”
8	Шугам хоолойн гэмтлээс ус ул хөрсөнд нэвчиж, ГДУ-ны найрлага, шинж чанарт нөлөөлөх	Ус дамжуулах шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтад тогтмол хяналт тавьж, гэмтсэн тохиолдолд засах	Гүний хоолойн шугам сүлжээ	Хяналт шалгалт болон засвар үйлчилгээ хийсэн тухай мэдээлэл	15,000,000	Тодорхойл ох боломжгүй	15,000,000	Жилийн турш	MNS0900:2018. Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар, хаягдал ус. Ерөнхий шаардлага”

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
9	Хаягдлын сангийн усан толионоос ууршилт бий болж усны алдагдал үүсэх	Хаягдлын сангийн ус буцаан татах цөөрмөөс усыг тогтмол шавхаж Баяжуулах үйлдвэрийн эргэлтийн усан санд нийлүүлэх	Хаягдлын сангийн үйл ажиллагаа	Хаягдлын сангаас дахин ашигласан усны хэмжээ	1,000,000	12	12,000,000	Сард нэг удаа	БОННУ, компанийн дотоод журам, Усны менежментийн төлөвлөгөө
10	Ундай сайрын голдиролд тохируулга хийснээр усны байгалийн горим алдагдах	Гадаргын ус шилжүүлэх суваг болон газрын доорх шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг хангах, тогтмол засвар үйлчилгээ хийх	Ундайн сайр, Шинэ бор овоогийн булаг	Хяналт шалгалт болон засвар үйлчилгээ хийсэн тухай мэдээлэл	5,000,000	2	10,000,000	Жилд 2 удаа	Усны тухай хууль, MNS0900:2018. Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Усны менежментийн төлөвлөгөө БОННУ
11	БУЦБ-аас бохир ус алдагдаж хөрсний бохирдол үүсэж, ГДУ-ны найрлага, шинж чанарт нөлөөлөх	БУЦБ-ын шугам хоолой, асгарсан усыг хязгаарлах сувгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих	Бохир ус цэвэршүүлэх байгууламжууд	Хяналт шалгалт болон засвар үйлчилгээ хийсэн тухай мэдээлэл	2,500,000	4	10,000,000	Улиралд 1 удаа	Усны тухай хууль, Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4586:1998, MNS4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар, хаягдал ус. Ерөнхий шаардлага”

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
									Компанийн дотоод журам, усны менежментийн төлөвлөгөө БОННУ “Усны тухай” хууль “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4586:1998
12	Хаягдлийн сангаас шүүрэл үүсэх, далан сэтрэх зэрэг ослоос ус алдагдаж, ул хөрсөөр дамжин ГДУ-ыг бохирдуулж болзошгүй	Шүүрлийн усыг тогтмол шавхах, шүүрэл хязгаарлах далангийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, засвар үйлчилгээ хийх	Хаягдлын сан	Шавхсан усны хэмжээ, Хяналт шалгалт болон засвар үйлчилгээ хийсэн тухай мэдээлэл	1,000,000	12	12,000,000	Сард нэг удаа	БОНБНУ, Компанийн дотоод журам, Усны менежментийн төлөвлөгөө
13	Ундны усны чанар алдагдах	Ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх	Гүний хоолойн ус татах байгууламж, Ус цэвэршүүлэх, савлах үйлдвэр	Тодорхойлох боломжгүй	14,000,000	Тодорхойлох боломжгүй	14,000,000	Тогтмол	Усны тухай хууль Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:1998. БОННУ, Компанийн дотоод журам, Усны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
14	Ус ашиглуулах дүгнэлтэнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглах, бусад зориулалтаар ус ашиглах, бусад худалдан борлуулж усны нөөцөд хохирол учруулах	Усны тухай хууль тогтоомж, дагалдах журам, ус ашиглах гэрээ, ус ашиглуулах дүгнэлтийг дагаж мөрдөх	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Усны төлбөрт төлсөн мөнгөн дүн	2,000,000	12	24,000,000	Сард нэг удаа	Усны тухай хууль болон холбогдох дүрэм журам, Ус ашиглах гэрээ, Ус ашиглуулах дүгнэлт
	Нийт						234,000,000		

5.3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Оюу толгой” ХХК нь газрыг зөв зохистой ашиглахтай холбоотой Монгол Улсын хууль, тогтоомжуудын шаардлагууд, байгаль орчны стандартууд, Оюу толгой уурхайн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд тусгагдсан амлалтууд, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шаардлагууд, Рио Тинто компанийн E14 стандартын шаардлагууд болон уурхайн хаалтын стратеги төлөвлөлт зэрэгт нийцүүлэн боловсруулсан Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөөг удирдлага болгон ажилладаг.

Энэхүү менежментийн төлөвлөгөөний хүрээнд багтах Газар хөндөх зөвшөөрөл (ГХЗ) олгох дотоод журмыг 2010 оноос хойш хэрэгжүүлж байна. Тус журмын дагуу аливаа газар хөндөх үйл ажиллагаа явуулах талбайн ургамалжилт, ховор ургамлын судалгааг гүйцэтгэж, нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай ховор ургамлын зүйл илэрсэн тохиолдолд хамгааллын арга хэмжээний зөвлөмжийг өгдөг. Ийнхүү ховор ургамлыг хамгаалах шаардлагыг биелүүлсэн талбайд ГХЗ олгодог. ГХЗ-өөр тухайн талбайн шимт, шимэрхэг хөрсийг хуулж хадгалах, тоосжилтыг багасгах, эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх, усны эх үүсвэрийг бохирдлоос хамгаалах, соёлын өвийг хамгаалах, ажилчид болон орон нутгийн иргэд, мал, зэрлэг амьтны аюулгүй байдлыг хангах зэрэг байгаль орчин, нийгмийн олон асуудлыг хянаж зохицуулдаг. Ирэх 2024 онд ГХЗ олгох компанийн дотоод журмын хэрэгжилтийг ханган, газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн 3 бүлэг ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 14. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө дотоодод хэрэгжүүлдэг Газар хөндөх зөвшөөрөл (ГХЗ) олгох, газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	ГХЗ хүссэн, олгосон талбайн тоо, хэмжээ	Газар хөндөх зөвшөөрлийн хүсэлт бүрт	18,000,000	Жилийн турш	MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт,
2		Зайнаас тандан судлах аргазүйг ашиглан газар ашиглалтыг хянах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлсэн эсвэл зөвшөөрөлгүй газар хөндсөн тохиолдолд байгаль орчны зөрчлөөр бүртгэж, зөрчлийг	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Зөвшөөрөлг үйгээр газар ашигласан талбайн тоо, хэмжээ	4	4,000,000	Улирал бүр	Рио Тинто компанийн E14 стандарт, Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө, Газар хөндөх зөвшөөрөл олгох болон

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		арилгах шаардлагатай арга хэмжээг авах						Оюу толгой компанийн дотоод журмууд
3		Үйл ажиллагааны багуудад газар хөндөх зөвшөөрөл, ховор ургамал хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой сургалт хийх	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Уурхайн үйл ажиллагааны багуудад	4	2,000,000	Улирал бүр	
	Нийт					24,000,000		

5.4. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Оюу толгой” ХХК-ийн явцын болон уурхайн хаалтын нөхөн сэргээлтэд стратегийн чухал ач холбогдол бүхий шимт болон шимэрхэг хөрсийг хамгаалах бодлого нь Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөөний нэг хэсэг болох Шимт болон шимэрхэг хөрсийг хамгаалах, Шимт болон шимэрхэг хөрсний чанарын шинжилгээ зэрэг дотоод журмуудаар зохицуулагддаг. Эдгээр журмуудыг Монгол Улсын холбогдох стандарт (MNS 5916:2008) болон олон улсын туршлагауд дээр үндэслэн боловсруулсан ба шимт, шимэрхэг хөрсийг зөв хуулах, хадгалах, чанарын үзүүлэлтүүдийг хянах зэрэгт тавигдах шаардлагуудыг тусгасан байдаг. Ирэх 2024 онд дээр дурьдсан компанийн дотоод журмуудын хэрэгжилтийг ханган, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дараах 4 бүлэг ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 15. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөрсөн бүрхэвчийг хөндөж хуулах хадгалах	Шимт, шимэрхэг хөрсний алдагдалаас сэргийлж үйл ажиллагааны баг тогтоосон хэмжээнд хуулж байгаа эсэх дээр хяналт тавьж хамтран ажиллах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	ГХЗ хүссэн, хөрс хуулах зөвлөмж олгосон талбайн тоо, хэмжээ	Газар хөндөх зөвшөөрлийн хүсэлт бүрт	6,100,000	Жилийн турш	MNS 5916:2008, Рио Тинто компанийн E14 стандарт, Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө, Газар хөндөх зөвшөөрөл олгох болон Оюу толгой компанийн дотоод журмууд
2		Газарзүйн мэдээллийн системд шимт, шимэрхэг хөрсний овоолгуудын байршил, хэмжээг бүртгэх, зурагжуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Хөрсний овоолгын зургийг хагас жилээр шинэчлэх, хаягжуулах	Урт хугацааны шимт, шимэрхэг хөрсний овоолго тус бүрт	2,000,000	Жилийн турш	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3	Хуулсан шимт болон шимэрхэг хөрсийг стандартын дагуу зөв хадгалж, ашиглах	Шимт болон шимэрхэг хөрсийг хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих	Уурхайн үйл ажиллагааны талбайн хэмжээнд	Шинээр шимт болон шимэрхэг хөрсний овоолго үүсгэх ГХЗ олгох үед	Шимт болон шимэрхэг хөрсний хуулалт хийгдэх бүрт	18,900,000	Жилийн турш	
4		Хадгалсан шимт, шимэрхэг хөрсийг нөхөн сэргээлт, ногоон байгууламжид эргүүлэн ашиглаж буй тооцоог хянах, бүртгэл хөтлөх	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Шимт, шимэрхэг хөрсний овоолгын ашиглалтын бүртгэл, овоолгын эзлэхүүн, талбай	Шимт болон шимэрхэг хөрсний эргүүлэн ашиглалт бүрт	3,660,000	Жилийн турш	
	Нийт					30,660,000		

5.5. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Өмнөх бүлэгт дурьдсан менежментийн төлөвлөгөөний чухал хэсэг болох ургамлан нөмрөгийн судалгаа, хамгааллын асуудлууд нь Ховор ургамлын хамгаалал, Ургамлын хяналт шинжилгээний журмуудаар зохицуулагддаг. Ирэх 2024 онд нэр дурьдсан компанийн дотоод журмуудын хэрэгжилтийг ханган, ургамлын аймаг, ургамлан нөмрөг, ховор ургамлын хамгааллын хүрээнд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дараах 3 бүлэг ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 16. Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөж доройтох, дарагдах, устгах	Газар ашиглалтын урьдчилсан төлөвлөлт гарсан болон газар хөндөх зөвшөөрөл (ГХЗ) хүссэн талбайд ургамлан бүрхэвч, ховор, нэн ховор ургамалд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээг шатлалын дагуу тодорхойлон, дүгнэлт зөвлөмж гаргах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Урьдчилан төлөвлөж буй болон ГХЗ хүссэн талбайд өгсөн дүгнэлт-зөвлөмжийн тоо	Газар хөндөх зөвшөөрлийн хүсэлт бүрт	10,010,000	Жилийн турш	Байгалийн ургамлын тухай Монгол Улсын хууль, Рио Тинто компанийн E14 стандарт, Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө,
2	доройтох, дарагдах, устгах	Уурхайн хашаан дахь хөндөгдөөгүй талбайн ховор ургамлын тархалтын мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр ашиглах, хамгаалах арга хэмжээг төлөвлөх. ГХЗ олгосон талбайд бүртгэгдсэн ховор ургамлын тархалтын мэдээллийг Газарзүйн мэдээллийн системд бүртгэж, зураглал гаргаж байх	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Урьдчилан төлөвлөж буй болон ГХЗ хүссэн талбайд өгсөн дүгнэлт-зөвлөмжийн тоо	Газар хөндөх зөвшөөрлийн хүсэлт бүрт	10,000,000	Жилийн турш	Газар хөндөх зөвшөөрөл олгох болон Ховор ургамлыг хамгаалах “Оюу толгой” ХХК-ийн дотоод журмууд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3		Ховор, нэн ховор ургамалд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах туршилт судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Ховор ургамлын туршилт хийх, удмын санг хадгалах зорилгоор ховор ургамлыг үржүүлэх, тариалах	ГХЗ-ийн хүсэлт бүрт	21,090,000	Жилийн турш	
	Нийт					41,100,000		

5.6. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээгээр “Оюу толгой” ХХК-ийн үйл ажиллагааны улмаас амьтны аймагт үзүүлж болзошгүй дараах нөлөөллийг тодорхойлж, бууруулах арга хэмжээг төлөвлөсөн.

Хүснэгт 17. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, гэрлийн нөлөөгөөр байршиж буй газар нутгаасаа үргэх, дайжих; мөн уурхайн олборлолт, барилга байгууламж цаашид өргөжин тэлэх явцад амьдрах орчны шууд хомсдол, хуваагдалд орох	Уурхайн аливаа үйл ажиллагаанаас зэрлэг амьтдад шууд нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор шинээр хөндөгдөж буй газруудад ховор амьтад, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах талаар зөвлөмж өгөх, шаардлагатай бол зөвшөөрөл олгохоос татгалзах	Уурхайн үйл ажиллагааны талбайн хэмжээнд	Газар Хөндөх Зөвшөөрөлд өгсөн дүгнэлтийн тоо	Шууд тооцох боломжгүй	Газар хөндөх зөвшөөрлийн хүсэлт бүрт	Шууд тооцох боломжгүй	Жилийн турш, газар хөндөх зөвшөөрлийн хүсэлт бүрт	Амьтны тухай хууль, Рио Тинто компанийн E14 стандарт, Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө
2	Дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, гэрлийн нөлөөгөөр байршиж буй газар нутгаасаа үргэх, дайжих; мөн уурхайн олборлолт, барилга байгууламж цаашид өргөжин тэлэх явцад амьдрах орчны шууд хомсдол, хуваагдалд орох	Ховор болон нэн ховор амьтад, тэдгээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөн, мөн төслийн талбайн дотор болон гадна анхаарал болгоомжтой зорчих талаар жолооч нарт сургалт явуулах	“Оюу толгой” ХХК-ийн үндсэн болон гэрээт компанийн ажилчид	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан ажилчдын тоо	3,000,000	Баяжмал тээврийн бүх жолооч нарт жилд 1 удаа	3,000,000	Жилд нэг удаа тээврийн бүх ээлжний жолооч нарт	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, Рио Тинто компанийн E16 стандарт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3		Хулан, хар сүүлтийн шилжилт хөдөлгөөний ажиглалт, судалгаанд үндэслэн замуудын зэрлэг амьтад ихээр гардаг, эрсдэл өндөртэй хэсгүүдийг үнэлж, шаардлагатай тохиолдолд хурдны хязгаарыг бууруулж, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	Оюу толгой-Гашуун сухайтын зам, Уурхайн хашаан доторх замууд	Зам хөндлөн гарсан хүзүүвчтэй амьтны тоо, давтамж, байршил,	5,100,000	Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээний тоо, байршил	5,100,000	Шаардлагатай тохиолдолд хурдны хязгаарыг бууруулах, анхааруулах тэмдэг байрлуулна	Нүүдэг туруутан амьтдад зориулсан гарц” байгуулах стандарт, Нүүдэллэдэг зүйлүүдийн конвенц, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шалгуур-6
4	Амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах, хууль бус агнуур, шувууд цахилгаанд цохуулах, цахилгааны утас мөргөх гэх мэтээр үхэж, хорогдох эрсдэлтэй	Монгол Улсын Улаан ном, бүс нутгийн болон олон улсын улаан данс (IUCN), бусад хууль тогтоомж, гэрээ конвенциор хамгаалагдсан ховор, нэн ховор зэрлэг амьтдын талаар сургалт зохион байгуулах	Оюу толгой компанийн үндсэн болон гэрээт компанийн ажилчид	Ажилчдын тоо	4,000,000	Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо	4,000,000	Жилийн турш	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Рио Тинто компанийн стандарт
5		Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох тухай компанийн дотоод журмын хэрэгжилтийг хангах үүднээс үзлэг шалгалт хийдэг харуул хамгаалалтын ажилчдад мэдээлэл өгөх	“Оюу толгой” ХХК-ийн хамгаалалтын компанийн ажилчид	Хяналт шалгалтын тоо, шалгалтаар илэрсэн зөрчлийн тоо, ажилчдын тоо	3,000,000	Шалгалтыг тогтмол хийх, явуулсан сургалтын тоо	3,000,000	Жилд нэг удаа харуул хамгаалалтын ажилчдад	Рио Тинто компанийн E16 стандарт, Байгаль орчин нөлөөллийн үнэлгээ
6		Уурхайн үйл ажиллагааны талбай, дэд бүтцийн шугам дагуух эндсэн амьтны сэг зэмийг зайлуулах, булж устгах	Уурхайн талбай, дэд бүтцийн шугам дагуу	Эндсэн амьтны тоо	2,000,000	Осол, эндэгдэл бүрт	24,000,000	Жилийн турш, амьтан эндсэн тохиолдолд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
7	Хур бороо багатай, ган зудтай үед зэрлэг амьтан үхэж хорогдох	Ган зуд болон байгаль, цаг уурын хүнд нөхцөл үүссэн тохиолдолд зэрлэг амьтдыг хамгаалах Биотехникийн арга хэмжээг зохион байгуулах	Ханбогд сумын нутагт	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	6,000,000	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	12,000,000	Цаг үеийн хүнд нөхцөл үүссэн үед	Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ханбогд сумын байгаль хамгаалагч нарын өгсөн албан зөвлөмжийг үндэслэн зохион байгуулна.
	Нийт						51,100,000		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Оюу толгой” ХХК нь уурхайн үйл ажиллагааны эхэн шат болох ашигт малтмалын хайгуул, барилга, дэд бүтцийн бүтээн байгуулалт болон малталт, олборлолтын явцад хөндөгдсөн газрыг үйл ажиллагааны явцад тасралтгүй нөхөн сэргээж байхаар дотоод журам, менежментийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж ирсэн. Эдгээр үйл ажиллагаа нь өмнө дурьдсан Газрын хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болох Нөхөн сэргээлтийн журмаар зохицуулагддаг. Өнгөрсөн 2010-2023 оны хугацаанд нийт 1835.63 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийж, үүнээс 609.69 га талбайд нь биологийн шатны ажлуудыг бүрэн гүйцэтгээд байна. Ирэх 2024 оны хувьд компанийн зүгээс биологийн нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээг нэмэгдүүлж, үүнтэй уяалдуулан зардлыг хэмжээг ихэсгэн доор дурьдсан ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Хүснэгт 18. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Техникийн нөхөн сэргээлт	Тухайн нөхөн сэргээх талбайн газрын дээрх болон доорх хог хаягдал, элдэв үлдэгдэл материалаас цэвэрлэж, шимт болон шимэрхэг хөрсийг дэс дарааллаар нь буцаан дүүргэлт хийж, өнгөн хөрс дэвсэж хэлбэршүүлэх, самнах. 2024 онд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийх талбай: • ОТ-ХБ чиглэлийн хатуу хучилттай замын барилгын үед ашиглагдсан шороон орд ВР-KBR05 түр замын хамт – 9.4 га • ОТ-ХБ чиглэлийн хатуу хучилттай замын барилгын үед ашиглагдсан оффис болон түр зам – 3.02 га • ОТ-ГС чиглэлийн замын барилгын ажлын үед	га	20.0	4,430,000.00	88,600,000	II-X сард	• MNS 5915:2008, • MNS 5917:2008, • MNS 5918:2008 • MNS 17.5.1.19-92, • Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал (2015 оны А-138) • Рио Тино компанийн E14 стандарт, • ОТ ХХК-ийн Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө, • Нөхөн сэргээлт хийх дотоод журам • Ховор ургамлыг хамгаалах дотоод журам


№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		ашигласан шороон орд болон бусад талбай						
2.	Биологийн нөхөн сэргээлт	ОТ-Гашуун сухайт чиглэлийн хатуу хучилттай замын барилгын ажилд ашигласан шороон ордууд - Хуурай үрлэгч ашиглан үрсэлгээ хийх - БУҮГ бойжуулсан 2-3 настай сөөг, сөөгөнцөр ургамлын суулгацыг тарих	га	40.0	13,000,000.00	520,000,000.00	IV-X сард	
3	Байгалийн ургамлын тарьц суулгац бэлтгэх	Нөхөн сэргээлтийг тогтоосон шалгуур үзүүлэлтүүдэд нийцүүлэн олон төрөл, зүйлээс бүрдсэн ургамлын бүрхэвчийг бий болгохын тулд нутгийн унаган ургамлын тарьц суулгацыг ургуулах, бэлтгэх	ш	90,000	-	35,510,000.00	Жилийн турш	
4	Хоолны хог нөхөн сэргээлтэнд ашиглах	Хоолны хаягдлаар компост бордоо бэлтгэх, бэлэн болсон бордоог нөхөн сэргээлтийн ажилд ашиглах	тн	10	-	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	
	Нийт					644,110,000		

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

7.1. Биологийн олон янз байдал талаар баримтлах бодлого

Оюу толгой уурхай нь Өмнийн говийн биологийн олон янз байдалд эерэг ахиу нөлөө үзүүлэхийг зорин ажилладаг билээ. Энэхүү зорилгодоо уурхайн хаалтын үед хүрсэн байхаар зорьж байгаа боловч төсөл хэрэгжих хугацаанд аль болох эрт хүрэх боломжуудыг эрэлхийлэх болно.

Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох нөлөөллийг шатлалтайгаар багасгах зарчмыг баримтална. Энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа нэн түрүүнд тэрхүү нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга замаар хийгдэнэ. Биологийн олон янз байдлын стратегид дээрх сөрөг нөлөөллийг бууруулах шатлалыг дараах байдлаар тус тус тодорхойлсон байдаг.



Зураг 26. Эерэг Нөлөө Ахиу байлгахын тулд хэрэгжүүлэх арга хэмжээний шатлал

Зайлсхийх - “Зайлсхийх арга хэмжээнүүд нь биологийн олон янз байдалд бодит нөлөөлөл үүсэхээс өмнө буюу олборлолтын болон баяжуулалт зэрэг уурхайн үйл ажиллагааг эхлүүлэхээс урьтан менежментийн өөрчлөлт хийх эсвэл тухайн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээнүүд юм. Үүнд өмнөх төлөвлөгөө үйл ажиллагаа, арга хэмжээг өөрчлөх шийдвэрүүд багтана”.

Багасгах – “Багасгах арга хэмжээнүүд нь аль хэдийн эхэлсэн олборлолтын болон боловсруулах үйл ажиллагааны үр дүнд биологийн олон янз байдалд учирч болох хохирлыг багасгаж болох арга хэмжээнүүд юм”.

Нөхөн сэргээх – “Нөхөн сэргээх арга хэмжээнүүд нь уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газар нутгуудад аюулгүй, тогтвортой газрын төрх, тогтцыг бий болгох бэлтгэл ажлууд, ургамалжуулж амьдрах орчныг дахин сэргээх ажил юм. Амьдрах орчныг сэргээх арга хэмжээ нь нөхөн сэргээлтээс бага зэрэг ялгаатай тал бий, энэ нь тухайн амьдрах орчныг эвдрэлд өртөхөөс өмнөх бүхий л нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ”.

Уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатуудад хийгдсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнүүд болон нэмэлт тодотголуудад тусгагдсан сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнүүдээс гадна уурхайн санхүүжүүлэгч олон улсын байгууллага болох Олон улсын санхүүгийн корпораци, Европын сэргээн босголт, хөгжлийн банк байгаль орчныг хамгаалах

талаар баримтлах гүйцэтгэлийн стандарт, шаардлагыг мөрдөн үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

Оюу толгой төслийг хэрэгжүүлэх үед биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, түүнийг бууруулах болон дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө, дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх стратеги, болон Эерэг нөлөөлөл ахиу байлгах зорилгод ямар арга замаар, хэдий хугацаанд хүрэх урьдчилсан төлөвлөгөө зэргийг уурхайн Байгаль Орчин Нийгмийн Нөлөөллийн үнэлгээний хавсралтаар 2012 онд хийж гүйцэтгэсэн.

Эдгээр үнэлгээ, урьдчилсан төлөвлөгөө зэргийг боловсруулахад Олон Улсын Санхүүгийн Корпорацын Гүйцэтгэлийн Стандарт-6, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Гүйцэтгэлийн Шалгуур-6 стандартуудыг баримтлан олон улсын байгаль хамгааллын ТББ болох “Фауна Флора Интернэйшнл”, “Де Байодиверсити Консалтанси” байгууллагаар гүйцэтгүүлсэн. Үүнд дараах тайлангууд орно:

- Биологийн олон янз байдлын удирдлагийн төлөвлөгөө
- Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө
- Дүйцүүлэн хамгааллын менежментийн төлөвлөгөө
- Эерэг нөлөөлөл ахиу үзүүлэх урьдчилсан таамаглал
- Биологийн олон янз байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөө
- Дээрх тайлангууд Оюу толгой ХХК-ийн цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулсан байгаа (<http://ot.mn/үйл-ажиллагааны-менежментийн-төлөвлөгөө/>).

Дээрх тайлангуудаас биологийн олон янз байдалд учирч болзошгүй нөлөөллийн үнэлгээний хэсгээс доор товч өгүүлье.

7.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 19. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хулан, хар сүүлтийн тоо толгойд үзүүлэх үлдэгдэл сөрөг нөлөөллийг “Хууль бус антай тэмцэх” төсөл хэрэгжүүлэх замаар дүйцүүлэн хамгаалах	1. Хамтарсан болон хөдөлгөөнт багийн гишүүд болон ТХГ-ын мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарт SMART аргачлал болон сургалт орох 2. Хамтарсан болон хөдөлгөөнт багийн хяналт шалгалтын ажлын зардлыг шилжүүлэх	Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Манлай, Номгон, Баян-Овоо сумууд болон Говийн Бага Дархан Цаазат газрын А, Б хэсгүүдэд	1,500,000 га	53,000,000	53,000,000	Жилийн турш	Төсөл хэрэгжих сумдын удирдлага, хамтран ажиллах газар, агентлагийн дарга нартай хийх гэрээ, харилцан ойлголцлыг санамж бичиг
2	Ханбогд - Манлайн замын дагууд хөндөгдсөн талбайг дүйцүүлэн хамгаалж нөхөн сэргээх	Байгалийн ургамлын тарьц суулгац ашиглан тарих	Өмнөговь аймгийн Ханбогд сум	5 га	3,000,000	15,000,000	IV-X сард	Ойн тухай хууль, БОНБНУ-ний тухай хууль, Өмнөговь аймгийн ИТХ-ийн 55-р тогтоол
	Нийт					68,000,000		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Оюу толгой” ХХК нь Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахдаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Олон улсын санхүүгийн байгууллага (ОУСБ)-ын Гүйцэтгэлийн стандарт 5 (ГС5)-ын шаардлага болон Рио Тинтогийн Орон нутгийн харилцааны стандарт хэм хэмжээг дагаж мөрдөх үүрэг хүлээн ажиллаж байна.

Хүснэгт 20. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Тайлбар	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	89 өрх	Хаалтын аудитын үнэлгээний зөвлөмж хэрэгжүүлнэ.	2011 оны Нөхөн олговрын гэрээтэй өрхүүд	89 өрх	Хаалтын аудитын зорилго, хамрах хүрээ Хөндлөнгийн аудит нь НШҮАТ –д заасан 2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн ажлын хэрэгжилт дууссан эсэх, нөлөөлөл бууруулах үйл ажиллагааны хүрээнд нөлөөлөлд өртсөн өрхүүдийн амьжиргаа бүрэн сэргээгдсэн эсэхийг тодорхойлно. Хаалтын аудитын үнэлгээг 2024 оны 1-р улиралд хийлгэж дуусгах бөгөөд Уг үнэлгээний зөвлөмжийн дагуух ажлуудыг 2024 онд хэрэгжүүлнэ	Жилийн турш	Монгол улсын хууль, журам, стандарт
2		Амьжиргааг дэмжих хөтөлбөрийн төслийг хэрэгжилтыг үргэлжлүүлэх, Гэрээний хугацаа дууссан төслүүд дээр хаалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх	2011 оны Нөхөн олговрын гэрээтэй өрхүүд	2018 оноос хойш хэрэгжиж байгаа төслүүд	Оюу толгой ХХК нь орон нутгийн хөгжлийг дэмжих бодлого баримталдаг бөгөөд олон янзын төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд гэрээ байгуулан хэрэгжүүлдэг. Жнь: Амьжиргаа дэмжих хөтөлбөр гэх мэт. Тиймээс энэ хүснэгтэнд эдгээр төсөл хөтөлбөрүүдийн зардлыг тусгаагүй болно.	Жилийн турш	Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Олон улсын санхүүгийн байгууллага (ОУСБ)-ын
3	1 өрх	Нэг өрхийн Нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлэх	2004, 2011 онд нөлөөллийн бүсэд орсон Нөхөн олговрын гэрээтэй өрх	1 өрх	НШҮАТ-нд Оюу Толгойн уурхайг Таван Толгой - Гашуунсухайт чиглэлийн нүүрсний замтай, мөн Ханбогд – Оюу Толгой чиглэлийн замыг Таван Толгойн хатуу хучилттай замтай холбох барилгын ажлын үед зам дагуу өвөлжөө бүхий гэр бүлд түр хугацааны нөлөөлөл	Жилийн турш	Гүйцэтгэлийн стандарт 5 (ГС5)-ын шаардлага

					учруулах тул тухайн гэр бүлтэй нөхөх олговрын гэрээ байгуулах талаар тусгасан		
--	--	--	--	--	---	--	--

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Оюу толгой” ХХК-ийн Орон нутгийн харилцааны хэлтсийн Соёлын өвийг хамгаалах үйл ажиллагаа нь Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйл 27.8, 27.10 болон Рио Тинтогийн орон нутгийн харилцааны стандарт Соёлын өвийн менежментийн системийн төлөвлөгөө, Соёлын өвийн хөтөлбөр бусад дүрэм, журам шаардлагад нийцүүлэн ажиллаж байна .

Хүснэгт 21. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Газар хөндөх зөвшөөрөл	Уурхайн үйл ажиллагааны бүх төрлийн газар хөндөх хүсэлтийг гаргаж зөвшөөрөл өгөх	Төслийн үндсэн болон гэрээт компанийн ажилчид	Хашаан дотор, гадна	-	-	Жилийн турш	Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө
2	Соёлын өвийн зааварчилгаа	Үндсэн болон гэрээт компанийн ажилчдад Соёлын өвийн зааварчилгаа өгөх		Нийт ажилчид	-	-	Жилийн турш	Дурсгалт зүйлс олдох баримтлах журам
3	Хяналт мониторинг	Чавгын агуй, Мангасын хүрээ, Дэмчогийн хийд, Шар цав, Хүрдэт агуй, Жавхлант хайрхан, Агуй уул, Хүрдэт агуй зэрэг дурсгалт газруудад мониторинг хийх	Түүх соёлын дурсгалт газрууд	8 дурсгал газар	Зардал тооцох боломжгүй		сард, улиралд	МУ-ын Соёлын өвийн тухай хуулийн 59 дүгээр зүйл.
4	Дурсгалт газрын цэвэрлэгээ	Дурсгалт газрын цэвэрлэгээ		2 дурсгалт газар	Зардал тооцох боломжгүй		Улиралд	

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5	Соёлын өвийн хайгуул, авран хамгаалах судалгаа	Хэрэв хайгуул судалгаа хийгдээгүй талбайнуудад шинээр газар хөндөх хүсэлт ирвэл авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулах	Судалгааны тайлан, зөвлөмж		Зардал тооцох боломжгүй	Зардал тооцох боломжгүй	Жилийн турш	МУ-ын Соёлын өвийн тухай хуулийн 27.8, 27.9 БСШУ сайд 222 дугаар тушаал
6	Соёлын биет бус өвийн судалгаа	ОТ төслийн бүсэд хийгдсэн угсаатны зүй болон биет бус өвийн үнэ цэнэд гарсан өөрчлөлтийн үнэлгээ	Судалгааны тайлан, зөвлөмж		Зардал тооцох боломжгүй	Зардал тооцох боломжгүй	Нэг удаа	Рио Тинто компаний Орон нутаг, нийгмийн гүйцэтгэлийн стандарт
7	Орон нутгийн оролцогч талуудтай хамтрсан төсөл	Ёс заншлын өргөө	Ажилчид, зочид	Зочдын бүртгэл	Ханбогд сумын Ахмадын хороо	22,0 сая төгрөг	Жилийн турш	Малчдын гомдлыг барагдуулах гэрээ. Гурван талт зөвлөл
8		Ундайн голын өв соёл	Ханбогд сумын иргэд	74 ахмад настан		146,5 сая төгрөг		
9	Шар цав, Ханбогд хайрханыг ЮНЕСКО-ийн Глобал Геопарк-д бүртгүүлэх бэлтгэл ажил	Нэмэлт судалгааны болон бусад шаардлагатай ажлууд	Төслийн багийн мэргэжилтнүүд, орон нутгийн холбогдох талууд			595 сая төгрөг	Жилийн турш	Рио Тинто Монгол, ЮНЕСКО-ын 3 жилийн хамтын ажиллагааны гэрээ
Нийт						773,5 сая төгрөг		

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Химийн бодисын хадгалалтад Монгол Улсын хууль, дүрэм журмууд болон олон улсын стандартад нийцсэн компанийн дотоод журам болох олборлолтын үеийн химийн бодисын удирдлагын төлөвлөгөөний дагуу хяналт тавин ажиллаж байна.

Оюу толгойн уурхайн одоогийн батлагдсан хүчин чадал, үйл ажиллагаа болон түүнд шаардагдах химийн бодисын байгаль орчинд нөлөөлөх байдал, эрсдэлийг тодорхойлохоор дараах эрсдэлийн үнэлгээнүүдийг хийлгэж мөрдлөг болгон ажиллаж байна.

Мөн уурхайн Хөрөнгө оруулагч нарын шаардлагын хүрээнд гүйцэтгэдэг Байгаль орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээний хүрээнд болон Рио Тинто группийн Аюултай, хортой Химийн бодистой холбоотой стандарт, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж эдгээрийг хөндлөнгийн болон дотоод аудит зохион байгуулах замаар тогтмол хяналт тавин ажиллаж байна.

- Аюултай материалын менежментийн журам,
- Асгаралтын үед мөрдөх журам,
- Аюултай материал болон түлшний менежменттэй холбоотой Аюултай Материалын Удирдлагын журам,
- Аюултай бодисын зөвшөөрөл авах зааварчилгаа,
- Нүүрс уст нэгдлээр бохирдсон хөрсний удирдлага болон эргэлтийн асуудалтай холбоотой Ландфарм ажиллуулах журам,

Уурхайн хэмжээнд ашиглаж буй бүх химийн бодисыг хор аюулын лавлах (ХАЛ)-тай байхыг шаардаж байгаа бөгөөд хавсрах зааварчилгаа нь хангалтгүй буюу тавигдаж буй шаардлагад үл нийцэж буй ХАЛ-тай химийн бодисуудыг уурхайн талбайд хэрэглэхийг бүрэн хориглоод байна.

Уг КемАлерт систем нь Олон улсад ашиглагддаг химийн бодисыг зүй зохистой аюулгүй ашиглахад зориулагдсан ухаалаг систем юм. Уг системийг ашигласнаар тухайн ашиглах гэж буй химийн бодисын талаар үйлдвэрлэгч, хор аюулын зэрэглэл, шаардлагатай нэг бүрийн хамгаалах хэрэгсэл гэх мэт мэдээллийг Монгол болон Англи хэл дээр авах боломжийг нийт уурхайн хүрээнд ажиллаж буй ажилчид авах боломжийг бүрдүүлж өгч байна. Цаашид уг систем дэх бодисын мэдээлэл тогтмол нэмэгдэж, сайжирч явах болно. Ирэх 2024 онд осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд доорх 19 бүлэг ажлыг хийхээр төлөвлөж байна.

Хүснэгт 22. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Байгалийн гамшигт үзэгдлүүд				
1	Аянга цахилгаан	Хамгаалах газардуулгын байгууламж буюу тэглэлтийн стандартаар тогтоосон шаардлагыг ашиглалтын үед тогтмол шалгаж нийцүүлж байх	Үйл ажиллагааны туршид	Эрчим хүчний сайдын 2014 оны 101 дүгээр тушаалын хавсралт: Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх дүрэм, MNS 5146:2002 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй байдал Хамгаалах газардуулга, тэглэлт стандарт
2	Үер	Үер болон хүчтэй салхи шуурганы дараа уурхайн тээвэрлэлт хийгддэг засмал болон сайжруулсан шороон зам эвдрэлд орсон эсэхийг шалгаж, эвдэрсэн тохиолдолд засах	Шаардлагатай тохиолдолд	Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/
3	Хүчтэй салхи шуурга	Байгууламжийн битүүмжлэлийг сайн байлгах, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл болсны дараа хяналтын үзлэг, техникийн үйлчилгээг хийж өгөх	Жилд 2 удаа	Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/
Үйл ажиллагаатай холбоотой				
4	ХС 2-н болон Лагийн талбайн хаягдал газрын хэвлий рүү нэвчих, газрын доорх усыг бохирдуулах	Аймгийн мэргэжлийн хяналт, байгаль орчны алба, сав газартай зөвлөлдөж, мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хяналтын цооног гаргаж ба тогтмол хянах	Барилгын ажил дууссаны дараа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль
5	ХС-ууд (сан 1, 2) тогтворжилт алдагдаж далан сэтрэх	Туршлага бүхий геотехникч эсвэл зохих туршлага бүхий уулын инженер, геологич хаягдлын сангийн тогтворжилтыг тогтмол хянах, эвдрэл, хагарал, нуралт ажиглагдсан тохиолдолд нэн даруй удирдлагад мэдэгдэж тухай бүрд засуулах арга хэмжээ авах	Жилийн турш	Гамшгийн тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Аюулгүй ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
6	Хяналтаас гадуурх дэлбэрэлт	Уурхайн талбайд аюулгүй ажиллагааны бүх дүрэм журам болон тэсрэх, тэсрэх бодистой холбоотой бусад бүх журмыг дагаж мөрдөх	Үйл ажиллагааны туршид тогтмол	Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг
7	Тоног төхөөрөмж, техникийн эвдрэл гэмтэл гарах	Тоног төхөөрөмжийг тогтмол шалгаж засвар үйлчилгээг тогтмол хийх, бүртгэл хөтлөх.	Үйл ажиллагааны туршид тогтмол	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
8	Аюултай бодисын асгаралт	Химийн бодисыг тухайн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байрлуулах /элс хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг/ болон зөөвөрлөх тээврийн хэрэгсэлд тогтмол байрлуулах, бүрэн бүтэн байдлыг шалгах	Жил бүр	Монгол Улсын Шадар сайд, БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/A/136/A/215 дугаар хамтарсан тушаалын хавсралт Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам Гурав. Химийн хорт болон аюултай бодисыг хадгалахад тавих нэмэлт шаардлага Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 12-р зүйл MNS ISO 13688:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын тусгай MNS 4992:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16.1.7
9		Шатах тослох материалын болон хаягдлыг түр хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж бэлтгэх, асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгах		
10	Химийн бодисын нөлөөнд өртөх	Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллагчдад аюулгүй ажиллагаа, болзошгүй осол, эрсдэлээс сэргийлэх болон анхны тусламж үзүүлэх сургалтыг зохион байгуулах	Жил бүр	Рио Тинтогийн удирдлагын тогтолцооны стандарт, E15 - Аюултай материал болон эрдсийн бус хог хаягдлыг хянах, бууруулах, H1 – Химийн хорт болон аюултай бодист өртөх өртөлтийг хянах
11		Химийн бодисын нөлөөнд өртөхөөс сэргийлэх, өртсөн үед үзүүлэх анхан шатны арга хэмжээний зааврыг агуулахад болон засварын төвд самбарт ил харагдахуйц газар байрлуулж шинэчлэх	Жил бүр	
12	Химийн бодисын агуулахын аюулгүй байдал алдагдах	Химийн бодисын агуулахад тогтмол хугацааны давтамжтайгаар хяналт хийж, тэмдэглэл хөтлөх - Агааржуулалтын системийн бүрэн бүтэн байдлыг 7 хоногт 1 удаа шалгах - Химийн бодис сав баглаа боодлыг 7 хоногт 1 удаа шалгах Химийн бодисын тавиурын механик бүрэн бүтэн байдлыг шалгах 7 хоногт 1 удаа	7 хоногт 1 удаа	
13	Халдварт өвчин	Эрүүл ахуйн бүсэд ажиллах ажилчдаас халдварт өвчний шинжилгээ авах	Жил бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Онц байдлын тухай хууль
14		Бүх нийтийг хамарсан цар тахал, онцгой өвчлөлтүүдээс шалтгаалсан улс нийтээр гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед төрийн байгууллагын шийдвэртэй уялдуулан ажилчдын эрүүл ахуйг хамгаалах төлөвлөгөөтэй байх	Шаардлагатай тохиолдолд	

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
15	Гал түймэр	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг байнгын бэлэн байлгах шаардлага хангаагүй галын хор багаж хэрэгслийг тухай бүрд шинэчлэн байршуулах. Галын хорын хугацааг шалгах.	Жил бүр	Галын аюулгүй байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга, MNS 5566:2005 Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм. MNS 4244 : 1994 Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал Ерөнхий шаардлага, MNS 5390:2004 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага.
16	Үйл ажиллагаатай холбоотой ахуйн осол	Өндөрт ажиллах, цахилгааны аюулгүй байдал болон бусад гол ажлын байрны эрсдэлийн сэдвээр өрнүүлдэг аянуудыг үргэлжлүүлэн хийх. Тэр дундаа түгээмэл тулгардаг эрсдэлийн учруулж болзошгүй хор хохирлыг ажилчдад хамтын оролцоотой, сонирхолтой байдлаар үзүүлж таниулдаг Эрсдэлийг үзүүлэх төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх	Жилийн турш	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
17		Үндсэн болон гэрээт ажилтан, зочдод зориулан аюулгүй байдлын чиг баримжаа, ерөнхий мэдлэг олгох сургалтыг үргэлжлүүлэн тогтмол явуулах	Жилийн турш	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
18		Түлшний агуулахын нөөцлүүр сав болон аянга зайлуулагчийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгах, ил гал гаргах, оч үсэргэхийг хатуу хориглох	Жилийн турш	MNS 4628:2013 Шатахуун түгээх станц. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага
19	Автомашинны осол	Замын хөдөлгөөний аюулгүйн дүрэм, Компанийн Удирдлагын тогтолцооны хүрээнд хэрэгжүүлж байгаа СЗ. Тээврийн хэрэгсэл ба жолоодлого стандартын шаардлагуудыг биелүүлэх.	Жилийн турш	Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга 2015/, Хөдөлмөрийн аюулгүй, байдал, эрүүл ахуйн тухай хууль, Рио Тинто ЭАБ. Стандарт СЗ – Тээврийн хэрэгсэл, түүнийг жолоодох, 2008 оны 12 дугаар сар, Уурхайн талбайн замын хөдөлгөөний дүрэм

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Оюу толгой” ХХК нь хог хаягдлын менежментийг урвуу пирамид аргачлалыг ашигладаг бөгөөд уг зарчимын хүрээнд нэн тэргүүнд хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин боловсруулалтын хувь хэмжээг нэмэгдүүлэхийг зорилго болгон ажилладаг. “Оюу толгой” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас гарсан эрдсийн бус хог хаягдлыг цуглуулах, ангилах, түр хадгалах, зарим нэр төрлийн энгийн хог хаягдлыг ландфиллд булшлах, орон нутгийн “Улаан загалмай” нийгэмлэгээр дамжуулан иргэд, аж ахуйн нэгжүүдэд сэргээн ашиглуулахаар шилжүүлэх, хог хаягдлыг дахин боловсруулах тусгай зөвшөөрөлтэй компаниудад шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг явуулж байна. Өнгөрсөн 2023 онд 18 дахин боловсруулах, дахин ашиглах болон устгах аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажилласан ба 2024 онд энэ хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн, хаягдлын менежменттэй холбоотой доорх 4 бүлэг ажлыг хийхээр төлөвлөж байна.

Хүснэгт 23. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал	Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Оюу толгой уурхайн талбайд	тн	5,000,000	Дахин ашигласан болон боловсруулсан хог хаягдлын хэмжээ	5,000,000	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль
2.	Аюултай хог хаягдал	“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	Хаягдлын удирдлагын төв	тн	Үйл ажиллагааны зардал	Аюултай хог хаягдлын хэмжээ	10,785,000	Жилийн турш	“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журам Оюу толгой уурхайн дотоод журам

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3.	Ахуйн болон аюултай	Батлагдсан маягт болон “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, засгийн газрын журамд заасан хугацаанд тайлагнах	Оюу толгой уурхайн хүрээнд	Нэгж тайлан	Тодорхойлох боломжгүй	Жилд нэг удаа	Үйл ажиллагааны зардал	Жилийн турш	Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам
4.	Ахуйн болон аюултай	Хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах үндэсний компаниудтай хамтран ажиллана.	Оюу толгой уурхайн хүрээнд	тн	Тодорхойлох боломжгүй	Хамтран ажиллаж буй компаниудын тоо	Гэрээнд заасан үнийн дүнгийн дагуу	Жилийн турш	Оюу толгой компанийн дотоод журам
5	Энгийн хаягдал	Уурхайн талбай болон нүүрсний замаас ОТ уурхай хүрэх зам дагууд хийссэн хаягдлыг тогтмол хугацаанд цэвэрлэх	Оюу толгой уурхайн хүрээнд	Цэвэрлэгээ зохион байгуулсан тоо	25,000,000 ₮	Улиралд нэг удаа	25,000,000 ₮	Жилийн турш	“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” журам Оюу толгой уурхайн дотоод журам
	Нийт						40,785,000		

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

12.1. Хөрсний хяналт шинжилгээ

Оюу толгойн уурхайн талбайн ерөнхий хөрсөн бүрхэвч нь доворхог, хад чулуурхаг байдаг бөгөөд газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог хоршил зонхилно. Өндөрлөгдүү газраар нимгэн чулуурхаг, хотгордуу газраар ердийн цөлийн бор саарал хөрстэй. Уурхайн талбайн хойд хэсгээр нимгэн чулуурхаг хөрстэй байхад, урд хэсгийн хотгордуу газраар элсэрхэг дов ихтэй элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нилээд их талбайг эзэлж байна. Хотгордуу газраар мараалаг хужирлаг шинжийн давсархаг хөрс хам бүрдэл үүсгэж бага зэрэг талбай эзэлнэ. Нийт нутаг дэвсгэр хэд хэдэн том жижиг хуурай сайраар хэрчигдсэн бөгөөд сайрын эрэг орчим газраар морфологийн хувьд үелсэн шинжтэй сайрын хөрс нилээд тохиолдоно. Ихэнх хөрсний гадарга нь говь, цөлийн хөрсний нийтлэг шинж чанар болох хайрга чулуун хучаастай.

Уурхайн үйл ажиллагааны үр дүнд хөрсний хими, физикийн шинж чанар, хүнд металлын агууламжид гарч болох өөрчлөлт, мөн түүнчлэн хөрсний чанар нь холбогдох стандартын шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянах зорилгоор хяналт шинжилгээтэй холбоотой доорх 3 бүлэг ажлыг 2024 онд хийхээр төлөвлөж байна.

Хүснэгт 24–т тусгагдсан хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Мөн компанийн зүгээс газар ашиглалтын явцад хөндөж буй талбай тус бүрээс шимт, шимэрхэг хөрсийг хуулж, хадгалах ажлуудыг тогтмол гүйцэтгэж ирсэн. Үүнтэй уялдан шимт, шимэрхэг хөрсний урт хугацааны овоолгуудын физик, хими, үржил шимт шинж чанарыг хянах ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна. Хөрсний хяналт шинжилгээтэй холбоотой доорх 4 бүлэг ажлыг 2024 онд хийхээр төлөвлөж байна.

Хүснэгт 24. Хөрсний хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Тоо хэмжээ, ш	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Хөрсний чанар- Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	Нийт 8 цэгт SMP-LA01-04, SMP-CHP (Төв дулааны станц), SMP-TSF1, 2 (Хаяглын сан) болон (Хог хаягдлын удирдлагын төв), SMP-WMC	Жилд нэг удаа	8	200,000	1,600,000	Гэрээт лабораторид шинжлүүлнэ	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Тоо хэмжээ, ш	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
2	Хөрсний чанар - Хүнд металлууд	Нийт 15 цэгт SMP-LA01-04, SMP-CHP (Төв дулааны станц), SMP-FS01 (Шатахуун түгээх станц), SMP-FS02 (Түлшний агуулах), SMP-OP (Ил уурхай), SMP-TSF01&02 (Хаягдлын сан), SMP-WMC (Хог хаягдлын удирдлагын төв), SMP-WWTP (Бохир ус цэвэршүүлэх байгууламж), аюултай хог хаягдлыг ландфилл, Ханбумбат нисэх онгоцны буудал, Химийн бодисын агуулах	Жилд нэг удаа	15	250,000	3,750,000	Гэрээт лабораторид шинжлүүлнэ	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3	Хөрсний чанар – Нефть, нефтийн бүтээгдэхүүн	Нийт 2 цэгт SMP-FS01 (Шатахуун түгээх станц), SMP-FS02 (Түлшний агуулах)	Жилд нэг удаа	2	875,000	1,750,000	Гэрээт лабораторид шинжлүүлнэ	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
4	Уурхайн талбайн хэмжээнд шимт хөрсний	Уурхайн талбайд байрлах урт хугацааны шимт хөрсний овоолгоос	жилд нэг удаа	80	200,000	16,000,000	Гэрээт лабораторид шинжлүүлнэ.	MNS 3298-90; Байгаль хамгаалал. Хөрс.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Тоо хэмжээ, ш	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	нөөцийн судалгаа							“Оюу толгой” ХХК-ийн Шимт, шимэрхэг хөрсний чанарын дотоод журам
	Нийт					23,100,000		

12.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ

Оюу толгойн уурхайн талбай нь Монгол орны уур амьсгалын мужлалаар гандуу дулаан зунтай бүсийн, хүйтэн өвөлтэй мужид байрладаг. Энэ ч утгаараа бусад бүс нутгуудтай харьцуулахад хур тунадас бага, хуурайшилт ихтэйгээс гадна, салхины хурд өндөр байдаг буюу тоосжилт үүсэх байгалийн суурь нөхцөлтэйгөөс гадна уурхайлах үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, дулааны станц зэрэг агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн нягтаршил өндөртэй. Эдгээрийн агаарын чанарт үзүүлэх нөлөө, цаашлаад агаарын чанарын холбогдох стандарт шаардлагуудыг хангаж буй эсэхийг хянахын тулд Оюу толгойн уурхайд цаг уурын болон агаарын чанарын байнгын станц ажиллуулах, явуулын хэмжилтийн багажаар хэмжилт хийх, мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх зэрэг доорх 7 бүлэг хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна (Хүснэгт 25).

Хүснэгт 25. Агаарын чанарын хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Цаг уур (агаарын хэм, салхины хурд, чиглэл, харьцангуй чийгшил, даралт, бороо цас, ууршилт, нарны цацрагжилт)	Уурхайн талбайд	Жилийн турш	Тогтмол	5,000,000	5,000,000	Campbell Scientific. UT30 автомат цаг уурын станц	Цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар ШЗ.П.01.03.2014 (Цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн заавар XIV дэвтэр. Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур орчны шинжилгээний газар)
2	Агаарын чанар – Тоос (PM2.5 ба PM10)	Уурхайн талбай дотор болон түүний орчимд байрлах тоосны хяналтын 5 цэгт буюу DMP-LA01, DMP-LA02, DMP-LA03, DMP-LA04, DMP-LA05,	Улирал тутамд	4	2,500,000	10,000,000	Dust Trak тоосны ширхэглэг хэмжих багаж	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
3	Агаарын чанар – Тоос (PM2.5 ба PM10)	Агаарын чанарын суурин станцууд: Уурхайн талбайд станц#1 (Хяналтын цэг),	Жилийн турш	Бодит цагийн байнгын хэмжилт	2,000,000	10,000,000	AQM65 агаарын	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
		станц#2 (Манлай ажилчдын суурин), станц#3 (ХУТ), станц#4 (ХС), станц#5 (Баяжуулах үйлдвэрийн хүдрийн овоолго)					чанарын бага оврын станц	
4	Агаарын чанар - орчны агаар дахь зарим хийнүүд (SO ₂ , NO ₂ , CO, O ₃)	Агаарын чанарын суурин станцууд: станц#1 (Хяналтын цэг), станц#2 (Манлай ажилчдын суурин), станц#3 (ХУТ), станц#4 (ХС)	Жилийн турш	Бодит цагийн байнгын хэмжилт	2,500,000	10,000,000	AQM65 агаарын чанарын бага оврын станц	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
5	Яндангийн хаягдал утаанд агуулагдах бохирдуулагчид буюу CO, SO ₂ , NO ₂ , үнс	Төв дулааны станц	Жилийн турш	Бодит цагийн байнгын хэмжилт	15,000,000	15,000,000	Утааны хийн байнгын хэмжилтийн систем	MNS 6298: 2011 Шинэ дулааны цахилгаан станц, дулааны станцын яндангаар агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
6	Дуу шуугиан (гадаад орчны дуу шуугианы түвшин)	Агаарын чанарын суурин станцууд: Уурхайн талбайд станц#1 (Хяналтын цэг), станц#2 (Манлай ажилчдын суурин), станц#3 (ХУТ), AQMN station#4 (ХС)	Жилийн турш	Бодит цагийн байнгын хэмжилт	2,500,000	10,000,000	AQM65 агаарын чанарын бага оврын станц	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
7	Дуу шуугиан (гадаад орчны дуу шуугианы түвшин)	Өдрийн болон шөнийн цагийн дуу шуугианы хэмжилтийг уурхайн талбайн эргэн тойронд байрлах 4 цэгт, мөн уурхайн ажилчдын	Улирал тутамд	4	2,500,000	10,000,000	Mediator дуу шуугианы түвшин хэмжигч	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
		суурингуудад тус бүр 1 цэгт буюу нийт 6 цэгт Өдрийн цагийн дуу шуугианы хэмжилтийг Ханбумбат нисэх буудлын эргэн тойронд 4 цэгт						
	Нийт					70,000,000		

12.3. Усны түвшин, чанарын хяналт шинжилгээ

Усны мониторингийн цооногуудын усны түвшинг мониторингийн хөтөлбөрт заасан хуваарийн дагуу хэмждэг бөгөөд ашиглалт явагдаж байгаатай холбогдуулан ашиглалтын худаг болон зарим цооногуудад усны түвшин хэмжигч автомат багаж суурилуулан өдөр тутам хэмжихээр тохируулсан. Мөн малчдын гар худгуудын усны түвшинг хэмжиж байна. 2024 онд доорх хүснэгтэд үзүүлсэн 17 хяналт шинжилгээний мониторингийн ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 26. Усны түвшний хяналт шинжилгээ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Оюу толгой уурхайн талбай, Ундайн сайрын дагуу хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөр								
1	Булгийн усны түвшин, устай сарын тоо, булгийн фото мониторинг	Шинэ бор овоо, Хөх хад, Мааньт, Буурал булаг, Будагт, Дундангийн ус, Хар хад гэсэн нийт 7 булаг	Сард нэг удаа	12	1,000,000	12,000,000	Усны түвшин, фото мониторинг	Булгийн усны мониторинг хийх стандарт ажлын журам
2	Гар худгийн усны түвшний хэмжилт	Эхэн Бурхант, Буурал, Хөх Хадны худаг зэрэг Ундай сайрын дагуу нийт 17 гар худаг	Сард нэг удаа	12	1,000,000	12,000,000	Solinst 101” усны түвшин хэмжигч гар багаж болон фото мониторинг	ГДУ-ны түвшинг усны түвшин хэмжигч гар багажаар хэмжих стандарт ажлын журам.
3	Цооног дахь усны түвшин	Ундай сайрын дагуух ГДУ-ны мониторингийн 15 цооног	Автомат түвшин хэмжигч багажаар цооногт хоногт нэг удаа Гар хэмжилтийг цооногт жилд 2 удаа	2	1,000,000	2,000,000	In-Situ LEVEL Troll автомат түвшин хэмжигч, Solinst 101” гар түвшин хэмжигч, метр.	ГДУ-ны түвшинг усны түвшин хэмжигч гар багажаар хэмжих стандарт ажлын журам, ГДУ-ны түвшинг автомат түвшин хэмжигч багажаар хэмжих стандарт ажлын журам.
4	Цооног дахь усны түвшин	Ил уурхай, Хаягдлын сан орчмын усны мониторингийн 10 цооног	Автомат түвшин хэмжигч	4	1,000,000	4,000,000	In-Situ LEVEL Troll автомат түвшин хэмжигч, Solinst	ГДУ-ны түвшинг усны түвшин хэмжигч гар багажаар хэмжих стандарт ажлын журам, ГДУ-ны түвшинг

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
			багажаар хоногт нэг удаа Гар хэмжилтийг улиралд нэг удаа				101” гар түвшин хэмжигч, метр.	автомат түвшин хэмжигч багажаар хэмжих стандарт ажлын журам.
5	Гадаргын урсац, булгийн ундарга (л/сек)	Шинэ бор овоо булаг	Сард нэг удаа	12	500,000	6,000,000	Халиагуурын арга.	Булгийн усны мониторинг хийх стандарт ажлын журам.
6	Гадаргын урсац, үерийн урсац (м³/хоног), үерийн түвшин (метр)	Ундай сайрын дагуу 3 цэгт	Үер урсах үед	Үер урсах үед	Багцын зардал	5,000,000	Үерийн урсгал хэмжих суурин цэгүүдэд, Урсцыг In-Situ LEVEL Troll автомат түвшин хэмжигч.	Үерийн урсац хэмжих стандарт ажлын журам
7	Эрүүл ахуй, бичил амьсудлалын үзүүлэлт, нийт бичил биетэн ба гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо (эмгэг төрүүлэгчийн тоо), өвчин үүсгэгч нян	Унд ахуйн усны эх үүсвэрүүд, гал зуухны угаалтуурын цоргоноос	Сард нэг удаа	12	1,000,000	12,000,000	100 мл ариутгасан зориулалтын уут Лабораторийн шинжилгээ.	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ,
8	Эрүүл ахуй, бичил амьсудлалын үзүүлэлт, нийт бичил биетэн ба гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо (эмгэг төрүүлэгчийн тоо), өвчин үүсгэгч нян	БУЦБ-аас цэвэрлэгдээд гарч буй усанд	Улирал нэг удаа	4	1,000,000	4,000,000	100 мл ариутгасан зориулалтын уут Лабораторийн шинжилгээ.	MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
9	Усны чанарын хээрийн үзүүлэлтүүд: рН, эрдэсжилт, ЦДЧ, температур	17 гар худаг болон 7 булаг	Улиралд нэг удаа	4	1,000,000	4,000,000	“Hanna” Усны чанарын хээрийн шинжилгээний (рН, Эрдэсжилт, ЦДЧ,температур) хэмжигч багаж.	Усны дээжний үндсэн үзүүлэлтийг талбар дээр гүйцэтгэх стандарт ажлын журам.
10	Усны химийн болон физикийн үзүүлэлт: рН, Эрдэсжилт, Температур, ЦДЧ, ХХХ, БХХ, умбуур бодис, анион ба катион, хүнд металлын агууламж: As, Ba, Be, B, Cd, Co, Cu, Cr, Ag, Se, Mo, Mn, Hg Pb, Zn, Ti, Fe, Al, U,	БУЦБ-аас цэвэрлэгдээд гарч буй усанд	Улиралд нэг удаа	4	2,500,000	10,000,000	Усны дээжний сав хэмжээ: 1000 мл Усны дээж авах ган ховоо хэмжээ: 1000 мл лабораторийн шинжилгээ.	MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага.
11	Усны химийн болон физикийн үзүүлэлт: рН, Булингар, Эрдэсжилт, ЦДЧ, умбуур бодис, хатуулаг, анион ба катион, органик бохирдуулагч, хүнд металлын агууламж, As, Ba, Be, B, Br, Cd, Co, Cu, Cr нийт, Ag, Se, Sr, Mo, Mn, Hg Pb, Zn, Ti, Fe, Al, U, CN-	Хаягдлын удирдлагын төвийн эргэн тойронд хяналтын 4 цооног	жилд нэг удаа лабораторийн шинжилгээ.	1	5,000,000	5,000,000	Усны дээжний сав хэмжээ: 1000 мл Усны дээж авах ган ховоо хэмжээ: 1000 мл, лабораторийн шинжилгээ.	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.
12	Усны химийн болон физикийн үзүүлэлт: рН, Булингар, Эрдэсжилт, ЦДЧ, умбуур бодис, хатуулаг, анион ба катион, органик бохирдуулагч, хүнд металлын агууламж, As, Ba, Be, B, Br, Cd, Co, Cu, Cr нийт, Ag, Se, Sr, Mo, Mn, Hg Pb, Zn, Ti, Fe, Al, U, CN-	Хаягдлын сангийн хяналтын цооногуудад	Урсцын доорх цэгүүдэд жилд нэг удаа лабораторийн шинжилгээ.	1	5,000,000	5,000,000	Усны дээжний сав хэмжээ: 1000 мл Усны дээж авах ган ховоо хэмжээ: 1000 мл, Лабораторийн шинжилгээ.	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
13	Баяжуулах үйлдвэрийн хаягдлын зутангийн хүчиллэг чанарын лабораторийн шинжилгээ: pH, EC, S (%), MPA (kg H ₂ SO ₄ /t), ANC (kg H ₂ SO ₄ /t), NAG pH4.5 (kg H ₂ SO ₄ /t), NAG pH7.0 (kgH ₂ SO ₄ /t), NAG pH, Хүнд металлууд:Ag, Al, As, B, Ba, Be, Bi, Ca, Cd, Co, Cr, Cu Fe, Ga, Hg, K, La, Mg, Mo, Na, Ni, P, Pb, S, Sb, Sc, Sr, Ti, U, V, W, Zn)	Баяжуулах үйлдвэрээс хаягдлын сан руу зутан хаях гарах шугам	Сард нэг удаа	12	750,000	9,000,000	Баяжуулах үйлдвэрийн хаягдлын зутангийн хүчиллэг чанарын лабораторийн шинжилгээ.	Дээжийг итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлнэ.
Гүний хоолойн ГДУ-ны ордын ашиглалтын үед хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөр								
14	Гар худгийн усны түвшин	Гүний хоолойн ГДУ-ны ордын талбай орчмын гар 10 гар худаг	Гүний хоолойн ГДУО-ын талбайд сард нэг удаа, алсын цэгүүдэд улиралд нэг удаа	12	750,000	9,000,000	Solinst 101” усны түвшин хэмжигч гар багаж.	ГДУ-ны түвшинг усны түвшин хэмжигч гар багажаар хэмжих стандарт ажлын журам.
15	Цооног дахь ГДУ-ны түвшин	Гүний хоолойн ашиглалтын худгууд болон хяналтын 10 цооног	Автомат түвшин хэмжигч багажаар хоногт нэг удаа Гар хэмжилтийг улиралд нэг удаа	4	2,000,000	8,000,000	In-Situ LEVEL Troll автомат түвшин хэмжигч, Solinst 101” усны түвшин хэмжигч гар багаж, Усны түвшин хэмжих	ГДУ-ны түвшинг усны түвшин хэмжигч гар багажаар хэмжих стандарт ажлын журам, ГДУ-ны түвшинг автомат түвшин хэмжигч багажаар хэмжих стандарт ажлын журам.
16	Усны чанарын хээрийн үзүүлэлтүүд: pH, эрдэсжилт, ЦДЧ, температур	Гүний хоолой дахь гар худаг болон булгуудад	Улиралд нэг удаа	4	2,500,000	10,000,000	Тухайн талбай дээр “Hanna” Усны чанарын хээрийн шинжилгээний (pH,	Усны дээжний үндсэн үзүүлэлтийг талбар дээр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
							Эрдэсжилт, ЦДЧ,температур) хэмжигч багаж	гүйцэтгэх стандарт ажлын журам.
17	Усны химийн болон физикийн үзүүлэлт: рН, Булингар, Эрдэсжилт, ЦДЧ, умбуур бодис, хатуулаг, анион ба катион, органик бохирдуулагч, хүнд металлын агууламж, As, Ba, Be, B, Br, Cd, Co, Cu, Cr нийт, Ag, Se, Sr, Mo, Mn, Hg Pb, Zn, Ti, Fe, Al, U, CN-	Гүний хоолойн ашиглалтын 28 худаг	Жилд нэг удаа	1	5,000,000	5,000,000	Усны дээжний сав хэмжээ: 1000 мл Усны дээж авах ган ховоо хэмжээ: 1000 мл лабораторийн шинжилгээ.	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.
	Нийт					122,000,000		

12.4. Ургамлын аймаг, ургамалжилт, нөхөн сэргээлтийн дараах хяналт шинжилгээний хөтөлбөр

Өмнийн говийн бэлчээрт цөлөрхөг хээр, заримдаг цөл болон жинхэнэ цөлийн экосистем голлон тархсан байдаг. Тус бүс нутагт ургадаг 16 зүйлийн ховор болон нэн ховор ургамлыг “Оюу толгой” компани нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай ургамлын жагсаалтад оруулсан байдаг. Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөллийг хянах, нөлөөллийг бууруулахаар хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд болон дүйцүүлэх хамгааллын ажлуудын үр дүнг хянах, нөхөн сэргээлтийн чанарыг тодорхойлох зорилгоор Өмнийн говийн хэмжээнд хайлаас, заг болон бэлчээрт төрөл бүрийн хяналт шинжилгээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 27. Ургамлын аймаг, ургамалжилт, нөхөн сэргээлтийн дараах хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Ургамалжилт - бэлчээрийн шимт чанарын мониторинг судалгаа	Дүйцүүлэн хамгаалах бүс нутгийн хэмжээнд	VIII/1-IX/15	Жилд нэг удаа	-	30,500,000.0	Жинхэнэ цөл, хээржүү цөл, цөлжүү хээрийн экосистемийн төлөөлөл бүхий байнгийн хяналт шинжилгээний талбайд ургамлын зүйлийн бүрдэл, баялаг, бүрхэцийг тодорхойлох. Шугаман цэгийн аргаар 30х30 метр хэмжээтэй судалгааны талбай тус бүрээс мэдээллийг авна.	Оюу толгой уурхайн олборлох, баяжуулах үйл ажиллагааны байгаль орчны үнэлгээ
2	Хайлаасны хяналт шинжилгээ	Ундай, Гашуун Сухайт, Бага Сухайт, Хөөвөрийн голын хашаалсан 16, хашаалаагүй 16 нийт 32 талбайд	VIII/1-IX/15	Жилд нэг удаа	-	10,750,000.0	Хайлаасны популяцид бэлчээрлэлтийн нөлөөг үзэх зорилгоор 30х30 метр талбайд ургамалжилтын бичиглэл хийнэ. Хайлаасны популяцийн сэргэн ургалтын байдлыг шалгахын тулд 30х30 метр талбайд хайлаасны цухуйцын тооллого хийнэ. Хайлаасны нягтшилыг 1 га-д тодорхойлох	Ургамлын бичиглэл хийх аргачлал
3	Загийн хяналт шинжилгээ	Ханбогд сумын хэмжээнд нийт 7	VIII/1-IX/15	Жилд нэг удаа	-	10,750,000.0	Загийн популяцид бэлчээрлэлтийн нөлөөг үзэх зорилгоор 30х30 метр	Ургамлын бичиглэл хийх аргачлал

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
		талбайн 24 хяналтын цэг					талбайд ургамалжлтын бичиглэл хийнэ.	
4	Нөхөн сэргээлтийн дараах хяналт шинжилгээ	Өмнөх жилүүдэд нөхөн сэргээлт хийсэн болон хяналтын талбайд;	VIII/1-IX/1	Жилд нэг удаа		7,500,000.0	Нөхөн сэргээсэн болон ойролцоох хөндөгдөөгүй талбайтай харьцуулан судлах	Нөхөн сэргээлт хийсэн болон хяналтын талбайд шугаман цэгийн аргаар, 30х30 м хэмжээтэй судалгааны талбай тус бүрээс мэдээллийг бүрдүүлж харьцуулах.
	Нийт					59,500,000		

12.5. Амьтны аймгийн хяналт шинжилгээ

“Оюу толгой” уурхай байрлаж буй Ханбогд сумын нутаг дэвсгэр нь хөхтөн амьтдын газарзүйн мужлалтаар Монгол-Түвдийн муж, Говийн дэд муж, Умард говийн тойрог болон Алтайн өвөр говийн тойрогт багтдаг. Одоогоор Оюу толгой орчимд нэг зүйл хоёр нутагтан, 11 зүйл мөлхөгч, 240 зүйл шувуу, 47 зүйлийн хөхтөн амьтан бүртгэгдээд байна. Иймээс уурхайн аливаа үйл ажиллагаанаас амьтдын зүйлийн олон янз байдал, популяцийн тоо толгой, нягтшилд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, үргэлжлэх эрчим ба цар хүрээг тогтооход энэхүү ажлын зорилго оршино. Амьтны хяналт шинжилгээний хөтөлбөрийг судалгааны ялгаатай талбайнуудад, өөр өөр зорилго, аргачлал, давтамжтайгаар төлөвлөн хэрэгжүүлж байна.

Хүснэгт 28. Амьтны аймгийн хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Шувууд								
1	Шувуудын мониторинг	Шүүрлийн усан сан, Цахилгааны шугам болон замын дагууд, Ханбумбат нисэх буудал орчим	Улиралд 1 удаа	4 удаа	1,000,000	4,000,000	Биологийн олон янз байдлын мониторинг судалгааны арга зүй.	Ажиглалтын арга, Дуран, дижитал зургийн аппарат, байршил тогтоогч (GPS), Survey123 маягт ашиглах
2	Могойч загалайн үүрлэлт, тархалт	Ханбогд сумын нутагт	Жилийн турш	2 удаа	1,000,000	2,000,000	GSM дамжуулагч бүхий шувуудын өгөгдөл дээр үндэслэх	Хайлаастай сайруудыг шалгаж, идэвхтэй үүрнүүдийг бүртгэх, ажиглах. Дуран, телескоп, GPS, хээрийн судалгааны мэдээ бүртгэх маягт
3	Хоолны үлдэгдлийг бордоо болгон бэлдэж буй талбай болон Хаягдлын удирдлагийн төвийн орчимд элдэв идэшт шувуудын тоо толгойг үнэлэх	Бордоо бэлтгэх талбай, Хаягдлын удирдлагын төв (ХУТ)	Сар бүр 1 удаа	12 удаа	100,000	1,200,000	-	Ажиглалтын арга, Дуран, Survey123 маягт ашиглах

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
4	Баяжуулах үйлдвэрээс хаягдлын сан руу нийлүүлж, тунгааж буй усны чанарын хяналтыг Газрын доорх усны ОХШХ-т тусгагдсаны дагуу тогтмол хийх	Хаягдлын сан	Улирал бүр 1 удаа	4 удаа	1,000,000	4,000,000	Усны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан	Лабораторийн шинжилгээ
5	Уурхайн барилга байгууламж, дэд бүтцийн шугамын дагуух зэрлэг амьтдын осол эндэгдэл, ажиглалтын бүртгэл	Уурхайн талбай дахь цахилгааны шугам, барилга байгууламж, авто замууд, Гүний хоолойн 35 кВ, 6 кВ-ийн цахилгааны шугам, Гашуун сухайтын зам, 220 кВ-ийн цахилгааны шугам	Сар бүр 1 удаа	12 удаа	500,000	6,000,000	-	Ажиглалт, бүртгэл хийх, Зургийн аппарат, байршил тогтоогч (GPS), Survey123 маягт ашиглах
Хөхтөн амьтад								
6	Жижиг мэрэгчид	Уурхай орчмын 4 талбайд: FMP-01, FMP-03, FMP-05, FMP-06, Шугам хоолойн дагууд 2 талбайд: FMP-07, FMP-08	VI сард 1 удаа	1 удаа	15,000,000	15,000,000	-	Барих-Тэмдэглэх-Дахин барих арга, Шерман амьд баригч, төмөр шугам, хээрийн судалгааны мэдээ цуглуулах маягт, зургийн аппарат ашиглах
7	Төслийн талбай дахь тууртан амьтны тоо толгой	Уурхайн талбайд	Сар бүр 1 удаа	12 удаа	500,000	6,000,000	Биологийн олон янз байдлын мониторинг судалгааны аргазүй.	Шугаман замнал болон цэгэн ажиглалтын арга, Дуран, зай хэмжигч, байршил тогтоогч (GPS), зургийн аппарат, Survey123 маягт ашиглах

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
8	Хулан, хар сүүлтийн нүүдэл, шилжилт хөдөлгөөн	Өмнөговь, Дорноговь аймаг	Жилийн турш	Жилийн турш	1,000,000	12,000,000	Сансарын дамжуулагчтай хүзүүвчтэй хулан, хар сүүлтийн өгөгдөл дээр үндэслэх	SIRTRACK болон VERTEX PLUS маркын Сансарын дамжуулагчтай хүзүүвч ашиглах
9	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналт	Оюу толгой - Гашуун сухайтын хатуу хучилттай зам	Жилийн турш	Автомат багаж тогтмол мэдээ хураадаг	500,000	6,000,000	Автомат багажны өгөгдөл дээр үндэслэх	Marksman 680 автомат багаж ашиглан хянах
Бусад								
10	Мөлхөгчид	Уурхай орчмын 6 талбайд: FMP-01, FMP-02, FMP-03, FMP-04, FMP-05, FMP-06, Шугам хоолойн дагууд 2 талбайд: FMP-07, FMP-08	VII–VIII сард 1 удаа	1 удаа	15,000,000	15,000,000	Биологийн олон янз байдлын мониторинг судалгааны аргазүй.	Шугаман замналын арга, Туузан метр, хээрийн судалгааны мэдээ цуглуулах маягт, термометр ашиглах
	Нийт					71,200,000		

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Оюу толгой” ХХК-ийн Байгаль орчны баг нь Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдлын (ЭМААБОАБ) хэлтэст харьяалагддаг бөгөөд 3 багийн нийт 22 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Баг тус бүр өөрсдийн ажлын үүрэгтэй. Хэлтсийн бүтэц, үндсэн үүргийн талаарх мэдээллийг дараах зургаас харна уу.



Зураг 27. Эрүүл Мэнд, Аюулгүй Ажиллагаа, Байгаль Орчин, Аюулгүй Байдлын хэлтсийн бүтэц, зохион байгуулалт.

“Оюу толгой” ХХК-ийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчин, орон нутгийн үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо нь Рио Тинтогийн стандарт загвар, олон улсын “Коппер Марк” сертификат болон бусад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн удирдлагын тогтолцооны стандартуудад нийцсэн. Олон улсын тэргүүн туршлагууд болох Олон Улсын Уул Уурхай, Металын Зөвлөл (ОУУУМЗ) (International Council on Mining and Metals ICMМ) -ын тогтвортой хөгжлийн төлөөх зарчмууд болон хариуцлагатай уул уурхайн үйлдвэрлэлд чиглэсэн Коппер Марк (Copper Mark) Олон улсын худалдааны тэмдэгтийн шаардлагуудыг хангаж байна.

2022 онд “Оюу толгой” ХХК нь УИХ-ын 2019 оны 92-р тоот тогтоолын дагуу Гүний хоолойн ГДУ-ны нөөцийг дахин үнэлэх ажлын даалгаварыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Усны газартай хамтран боловсруулгу 2023 онд эрх бүхий хөндлөнгийн, мэргэжлийн олон улсын зөвлөх байгууллагыг сонгон шалгаруулсан ба 2024 онд нөөцийн дахин үнэлгээг гүйцэтгэх болно.

Мөн орон нутгийн уст цэгийг нэмэгдүүлэх, зэрлэг ан амьтанд шаардлагатай ус цэгийг бий болгох зорилгоор үерийн ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах судалгааны ажлыг 2023 онд мэргэжлийн байгууллагаар хийлгэх бөгөөд судалгааны ажлын үр дүн, төвөгшил зэргийг харгалзан үзэж төслийг 2024 онд дуусгахаар төлөвлөсөн.

Өмнговь аймгийн БОАЖГ-аас тавьсан хүсэлтийг дагуу “Говийн бага” ДЦГ зэрлэг амьтанд зориулсан уст цэг байгуулах хэрэгцээ шаардлагыг мэргэжлийн байгууллагатай хамтран үнэлэнэ.

Хаягдлын сангаас гарч буй шүүрэлтэй холбоотой “Турван талт зөвлөл” болон зөвлөлөөс байгуулагдсан ажлын хэсэгтэй ил тод нээлттэй үргэлжлүүлэн хамтран ажиллах болно. Шүүрлийн усны байгаль орчин, хөрсөнд үзүүлэх болзошгүй нөлөөллийг нарийвчлан тодорхойлох ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх болно. Мөн уг ажлын хүрээнд Ундайн сайрын гольдролын тохируулга хийгдсэн далангаас дооших хэсэг дэх сайрын нөлөөллийг давхар тодорхойлно.

Жил бүр уламжлал болон зохион байгуулдаг байгаль орчныг хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг жилийн турш тогтсон өдрүүдэд Өмнөговь аймгийн БОАЖГ болон Ханбогд сумын ЗДТГ, Ханбогд сумын сургуулиудтай хамтран зохион байгуулна. Эдгээр тэмдэглэлт өдрүүдээр дамжуулан компанийн ажилчид, орон нутгийн иргэд, олон нийтийг байгаль орчныг хамгаалахад уриалах, зөв дадал бий болгоход чиглэсэн ажлуудыг хийх болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжиж буй "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Оюу толгой ХХК-ийн хэрэгжүүлэх “100 сая мод” хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Уг хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн хэмжээнд говь, цөлийн бүсэд загаар ойжуулах шаардлагатай газруудыг тодорхойлох болно.

Хүснэгт 29. 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгасан ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Ажлын хэсгийн зөвлөмжинд тусгасан ажил	Урьдчилан тооцсон төсөв, төг	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
А. Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр:				
1	Оюу толгой уурхайгаас Таван толгой нүүрсний зам хүртэлх ачаа тээврийн 12км шороон замыг хатуу хучилттай болгох, хатуу хучилттай зам ашиглалтад орох хүртэлх хугацаанд шороон замын усалгаа арчилгааг сайжруулах, тоосжилт бууруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах.		Барилгын ажлын турш	“Оюу толгой” ХХК–ийн Байгаль орчны хэлтэс
2	Хоёроос доошгүй булгийн эхийг хамгаалах, ундаргыг нэмэгдүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх /Булган сумын Нүцгэн булгийн эхийг хамгаалж, хөв цөөрөм байгуулсан ажлыг үзэж туршлага судлан, зургийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх/		Төлөвлөсөн хугацаанд	“Оюу толгой” ХХК–ийн Байгаль орчны хэлтэс
3	Зэрлэг амьтдын амьдрах орчныг сайжруулах зорилгоор автомат ажиллагаатай ус цэг бий болгож, хяналт мониторинг хийх камер суурилуулах, өвөл хаврын улиралд биотехникийн арга хэмжээг эрчимжүүлэх.		Өвөл, хаврын улиралд	“Оюу толгой” ХХК–ийн Байгаль орчны хэлтэс
Б. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд:				
1	Идэвхигүй хаягдлын талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, дулааны цахилгаан станцаас гарч буй хаягдал үнсийг дахин ашиглах.		Жилийн турш	“Оюу толгой” ХХК–ийн Дэд бүтцийн хэлтэс
2	Идэвхигүй хаягдлын талбайд зориулалт бусаар хаясан шингэн хаягдлыг зайлуулах.		Жилийн турш	“Оюу толгой” ХХК–ийн Дэд бүтцийн хэлтэс
В. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд:				
1	Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачлагаар зохион байгуулагдах “Тэрбум мод” үндэсн хөдөлгөөн, Өмнөговь аймгийн ИТХ-ын 56-р тогтоолоор батлагдсан “Тонн баялаг-Нэг мод” тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдад тус бүр 20 га талбайд ойжуулалт хийх.		2024 онд	“Оюу толгой” ХХК–ийн Байгаль орчны хэлтэс

2	Сэврэй суманд байрлах баруун бүсийн сум дундын ойн ангийг түшиглэн Мод үржүүлгийн газар байгуулах.		2024 онд	“Оюу толгой” ХХК–ийн Байгаль орчны хэлтэс
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлагдсан загварын дагуу төлөвлөх, төлөвлөлтийг сайжруулах, хийх ажлыг нарийвчилан тодорхой тусгах, тайлангийн бичилтийг сайжруулах, тоо баримт, үндэслэлийг тодорхой оруулах, баримт нотолгоог хавсралтаар бүрэн оруулах /2022 оны ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй/		БОМТ, БОМТ хэрэгжилтийн тайлан бэлтгэх үед	“Оюу толгой” ХХК–ийн Байгаль орчны хэлтэс Орон нутгийн хэлтэстэй хамтран
Г. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд:				
1	Соёлын биет бус өвийг хөгжүүлэх зорилтыг тодорхойлох, тэмээн соёлыг дэмжиж ажиллах.		Жилийн турш	“Оюу толгой” ХХК–ийн Орон нутгийн хэлтэс
2	Дэмчигийн хийдийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг дэмжиж ажиллах.		Жилийн турш	“Оюу толгой” ХХК–ийн Орон нутгийн хэлтэс
Д. Аймаг, сумын орон нутгийн төр захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөнд:				
1	Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг 3-аас доошгүй удаа сургуулийн хүүхдүүд болон иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулах.		Тогтсон хугацаанд	“Оюу толгой” ХХК–ийн Байгаль орчны хэлтэс
2	Багуудын хуралд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын явцыг улирал тутамд танилцуулж байх.		Улирал бүр	“Оюу толгой” ХХК–ийн Байгаль орчны хэлтэс Орон нутгийн хэлтэстэй хамтран

Хүснэгт 30. Нэмэлтээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, төг	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Гүний хоолойн ГДУ-ны ордын ашиглалтын үеийн нөөцийг дахин үнэлэх	50,000,000	2023-2024 онд	“Оюу толгой” ХХК-ийн Байгаль орчны хэлтэс	Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны Газрын удирдамжийн дагуу Гүний хоолойн газрын доорхи усны ордын нөөцийг дахин үнэлж, баталгаажуулах ажлыг зохион байгуулна.
2	Ажил мэргэжлээ сурталчлах хөтөлбөрүүд (Гүнээсээ хайрлая, Бусад уурхайнуудтай туршлага солилцох хамтын ажиллагаа, “Light tower” буюу “Гэрэлт цамхаг” төсөл, ОТ уурхайн ажилчдад байгаль орчны үйл ажиллагааг танилцуулах аялал, Хайгуулч сурагч хөтөлбөр г.м.)		2024 онд	“Оюу толгой” ХХК-ийн Байгаль орчны хэлтэс	Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, сайн туршлагаа мэргэжил нэгтнүүд, мэргэжлээ сонгохоор завдаж буй дунд сургуулийн сурагчид болон уурхайн бусад хэлтсийн ажилчдад үзүүлж таниулах, сурталчлах, цаашлаад нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх ач холбогдолтой хөтөлбөрүүд юм.
	Нийт	50,000,000			

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 31. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Өмнөговь аймгийн Даланзадгад суманд зохион байгуулагдах “Нээлттэй өдөрлөг”-т оролцож, 2024 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийн танилцуулга хийнэ.	Нээлттэй өдөрлөг зохион байгуулах	Байгаль орчны хамгаалах арга хэмжээнүүдийн хэрэгжилт, ашиглаж буй багаж, тоног төхөөрөмжийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгөх	Хугацаны тов тодорхойгүй	5,000,000	“Оюу толгой” ХХК –ийн Орон нутгийн хэлтэс болон бусад хэсэг нэгжүүд	Өмнөговь аймгийн Даланзадгад хот
2	Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Манлай сумуудад зохион байгуулагдах “Нээлттэй өдөрлөг”-т оролцож, 2024 онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийн танилцуулга хийнэ.	Нээлттэй өдөрлөг зохион байгуулах	Байгаль орчны хамгаалах арга хэмжээнүүдийн хэрэгжилт, ашиглаж буй багаж, тоног төхөөрөмжийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгөх	Хугацаны тов тодорхойгүй	1,000,000	“Оюу толгой” ХХК –ийн Орон нутгийн хэлтэс болон бусад хэсэг нэгжүүд	Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Манлай сум
3	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгууллагын цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулах	Компанийн албан ёсны вэб хуудас www.ot.mn	Байгаль орчны хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүн	Хугацаны тов тодорхойгүй	Зардалгүй	БО-ны хэлтэс	www.ot.mn
4	Уурхайчин сэтгүүлд байгаль орчны чиглэлээр хийсэн ажлуудын танилцуулгыг улиралд нэг удаа тогтмол оруулна	Уурхайчин сэтгүүл	Байгаль орчны хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тайлан	Улирал бүр	Тодорхойгүй	БО-ны хэлтэс, Олон нийттэй харилцах хэлтэс, Орон нутгийн хэлтэс	Өмнөговь аймгийн Ханбогд сум

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
5	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь үзэж шалгах ажлын хэсгийн үзлэг шалгалт	Шалгалтын дүгнэлт	Байгаль орчны хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн үр дүн	4-р улирал	Тодорхойгүй	БО-ны хэлтэс, Орон нутгийн хэлтэс	Оюу толгой уурхайн талбай
6	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг орон нутгийн захиргаанд хүргүүлэх, танилцуулах	Танилцуулга хийх	2024 оны БОМТ биелэлт, үр дүн	1-р улирал	Тодорхойгүй	БО-ны хэлтэс, Орон нутгийн хэлтэс	Өмнөговь аймгийн Ханбогд сум
9	Байгаль орчны менежментийн тайланг орон нутгийн иргэдийн төлөөлөл болох Гурван Талт Зөвлөлд танилцуулна	Үйл ажиллагааны тайлан	2024 оны БОМТ биелэлт, үр дүн	2024 онд	Тодорхойгүй	БО-ны хэлтэс, Орон нутгийн хэлтэс	Өмнөговь аймгийн Ханбогд сум
11	“Оюу толгой” ХХК-ийн сар бүрийн ус ашиглалтын мэдээллийг улирал тутамд компанийн вэб хуудас www.ot.mn болон олон нийтэд нээлттэй байдлаар байршуулна	Компанийн албан ёсны вэб хуудас www.ot.mn	Ус ашиглалтын мэдээ	Улирал бүр	Тодорхойгүй	БО-ны хэлтэс	N/A
Нийт					50,000,000		